

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 17-НЫ
ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-27
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	
	1.Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны “Стратеги төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 11 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	28-29
	2.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол нарын 10 гишүүн 2019.10.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	29
	3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 10 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	30-81

Хураангуй тэмдэглэл

Гурав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 10 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Иргэний

улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, Хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, Б.Хатантуул, референт Ж.Ганчимэг, Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, О.Баасанхүү нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн хариулж, тайлбар хийв.

3.Төслөөс 18 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3, 21 дүгээр зүйлийн 21.11, 60 дугаар зүйлийн 60.2, 60.5, 63 дугаар зүйлийн 63.2, 63.4, 66 дугаар зүйлийн 66.16, 66.17, 66.18, 68 дугаар зүйлийн 68.15, 68.16, 68.17, 68.18, 72 дугаар зүйлийн 72.19, 72.20, 72.21, 76 дугаар зүйлийн 76.6, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойргоос сонгогдсон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийн “болон төв комиссын дарга” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “, 22” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг, 76 дугаар зүйлийн 76.7 дахь хэсгийн “Энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг, 78 дугаар зүйлийн гарчгийн **“Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх,”** гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг “нэр дэвшигчийг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “Сонгуулийн хороодод” гэж, 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага” гэснийг “Сонгуулийн хороод” гэж, 20 дугаар зүйлийн 20.19 дэх хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын” гэснийг “Сонгуулийн хороодын” гэж, 20 дугаар зүйлийн 20.20 дахь хэсгийн “байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “сонгуулийн хороонд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн доор дурдсан зүйл, хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг:

“14.1.Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороог нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон хэсгийн хороо нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид “сонгуулийн

хороод” гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.”

Төслийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.”

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Нам, эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлнэ.”

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:

“32.1.Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн бие даан нэр дэвшиж болно.”

Төслийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг:

“67.2.Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.”

Төслийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг:

“73.1.Тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.”

Төслийн 75 дугаар зүйл:

“75.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.

75.2.Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

75.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.

75.4.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.”

Төслийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг:

“78.1.Энэ хуулийн 4.3.3-т заасан үндэслэлээр нөхөн сонгууль явагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“18 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

“25 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “иргэний улсын бүртгэлийн биеийн давхцалгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дугаар авсан эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9 дэх заалт нэмэх, хуулийн нэр томъёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.8.“Цахим хуудас” гэж бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг;

3.1.9.“Ял эдэлж байгаа” гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үнсдэн болон нэмэгдэл ялаа эдэлж дуусаагүй, эсхүл торгох ялыг биелүүлээгүй байхыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Харилцаа холбооны

зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир нар хариулж, тайлбар хийв.

9.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас” гэснийг “аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “талаар” гэсний ард “байр сууриа илэрхийлэх,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хороог” гэсний дараа “тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “өмнө” гэсний дараа “тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.16 дахь хэсгийн “журмыг” гэснийг “, сонгогч шилжих журам болон маягт, загварыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “энэ хуулийн 23.2-т заасны дагуу цахим хуудаст байрлуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

15.Төслийн 26 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26, 27 дугаар зүйл болгох:

“26 дугаар зүйл.Сонгогч шилжих

26.1.Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

26.2.Нэр дэвшигч болон энэ хуулийн 38.3-т заасан менежер, шадар туслагч сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.

27 дугаар зүйл.Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох

27.1.Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

27.3.Энэ хуульд заасан нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 27.1, 27.2-т заасан иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуустал үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.4.Ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулахаар товлон зарласан эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор улсын бүртгэлийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “дараах” гэсний дараа “асуудлыг олонхиороо шийдвэрлэх бөгөөд” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.3, 30.4.4 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.2.6, 33.3.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.7.Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Д.Эрдэнэбат нар үг хэлэв.

20.Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “маягтад” гэсний дараа “тухайн сонгуулийн тойргийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг “ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

22.Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “600” гэснийг “200” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг доор дурдсанаар нэмэх:

“40.2.8.Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “хоёроос” гэснийг “дөрвөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.3.Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум,

дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг “Энэ хуулийн 42.3-т заасны дагуу тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар болон ухуулах хуудас байршуулахыг хориглоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “Ухуулах” гэснийг “Нэр дэвшигч нь ухуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 42.14 дэх хэсгийг доор дурдсанаар нэмэх:

“42.14.Энэ хуулийн 40.2.8-д заасан сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.8, 43.9 дэх хэсгийн “самбарыг” гэснийг “самбар, дэлгэцийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “ухуулах байр,” гэсний дараа “сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт, арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.8.Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийн 47.9.2 дахь заалтын “сүүлийн зургаан сарын” гэснийг “ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир нар хариулж, тайлбар хийв.

33.Төслийн 47 дугаар зүйлийн 25 дахь хэсгийн “47.2, 47.5-47.8, 47.11-47.19-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.7.Энэ хуулийн 36.3, 48.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо Цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 48 дугаар зүйлийн 48.8 дахь хэсгийн “Интернэтийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсгийн “хороо” гэснийг “хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Төслийн 48 дугаар зүйлд “Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “нь” гэснийг “тус бүр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “гурван сая” гэснийг “таван сая” гэж, “арван таван сая” гэснийг “хорин сая” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төслийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“55.2.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 55.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хандив өгч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Төслийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар нар хариулж, тайлбар хийв.

44.Төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 дахь хэсгийн “22.00” гэснийг “21.00” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	10
Бүгд:	12

16.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн хариулж, тайлбар хийв.

45.Төслийн 63 дугаар зүйлийн 63.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.13.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Төслийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Төслийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсгийн “Бие эрхтний согог, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдал,” гэснийг “Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “гурав хүртэл” гэснийг “дөрөв хүртэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
-------------	---

Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан хариулж, тайлбар хийв.

49.Төслийн 69 дүгээр зүйлийн 69.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“69.2.5.Сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50.Төслийн 72 дугаар зүйлийн 72.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“72.11.Энэ хуулийн 72.5.3-т заасны дагуу саналын хуудсыг дахин тоолоход сонгогчдын саналыг тоолохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

51.Төслийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн “15 хоногийн” гэсний дараа “Улсын Их Хурал болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

52.Төслийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79.3.Энэ хуулийн 9.10-т заасны дагуу дахин сонгууль явуулахад улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээс ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулиар гаргаж хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5

Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53.Төслийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн дараа доор дурдсан агуулга бүхий хэсэг нэмэх, үүнтэй холбоотойгоор 80.3 дахь хэсгийг “ирцийг” гэснийг “ирц, саналын тоог” гэж, “ирц” гэснийг “ирц, саналын тоо” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалтыг “Нэмэлт санал хураалт гэж энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу явагдах санал хураалтыг,” гэж тус тус өөрчлөх:

“Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрт нэмэлт санал хураалт явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

54.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.5 дахь хэсгийн “81.5.” гэснийг “Тайлбар.” гэж, “их” гэснийг “илүү” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

55.Төслийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“48.5.Энэ хуулийн 48.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

56.“Зар сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын шинжтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “заасны” гэсний дараа “дагуу” гэж, “хангасан” гэсний дараа “Монгол Улсын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын /цаашид “Улсын Их Хурлын” гэх/ сонгууль нь” гэснийг “Монгол Улсын Их Хурлын сонгууль нь /цаашид “сонгууль” гэх/” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг “Монгол Улсын Их Хуралд /цаашид Улсын Их Хурал гэх/-д” гэж, мөн зүйлийн “4.4.1, 4.4.2, 4.4.3, 4.4.4” гэснийг “4.5, 4.6, 4.7, 4.8” гэж, мөн заалтуудын “сонгуулийг;” гэснийг “сонгуулийг ойлгоно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.2 дахь заалтын “26.6” гэснийг “26.3” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “24.1” гэснийг “24.2” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “21.1” гэснийг “25.1” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “21.5” гэснийг “25.5” гэж, 72 дугаар зүйлийн 72.1.2 дахь заалтын “78.5” гэснийг “72.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмж, хассантай холбогдуулан төслийн дугаар, эшлэлийг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн “гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2.1 дэх заалтын “сонгуулийн тухай” гэсний дараа

“болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн “8.3.8.Сонгууль” гэснийг “ээлжит бус, дахин, нөхөн сонгууль,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: Төслийн 1 дүгээр зүйлийн 46.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.4.Төрийн жинхэнэ албан хаагч нь Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: Төслийн 2 дугаар зүйлээс “11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” гэж, мөн зүйлийн” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулга бүхий 3 дугаар зүйл нэмэх:

3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

С.Бямбацогт: 1.Төсөлд "Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “заасан хэмжээгээр” гэсний дараа “шүүх,” гэж нэмэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1, 6, 11 дэх хэсгийн “учруулсан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 4 дэх хэсгийн “явуулсан” гэсний дараа нь “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 15, 16 дахь хэсгийн “оруулсан” гэсний дараа нь “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 23 дахь хэсгийн “тараасан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 31 дэх хэсгийн “устгасан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 47 дахь хэсгийн “хийсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 74 дэх хэсгийн “хэрэглэсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж, 30, 31, 32 дахь хэсгийн “бол” гэсний дараа “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлд заасан зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн харьцаанд нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 43.4 дэх заалтын “энэ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 38 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.Нэр дэвшигч нь сонгуулийн хуульд заасан цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлээгүй, бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 48 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банканд нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд хуульд заасны дагуу төвлөрүүлж, зарцуулах талаар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 49 дэх хэсгийн “цуглуулах” гэснийг “цуглуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 39 хэсгийн “нийтэлсэн” гэсний дараа “, цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн” гэж, 40 дэх хэсгийн “Интернэтийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж, 50 дахь хэсгийн “бол” гэсний дараа “хууль бусаар зарцуулсан хөрөнгө, орлогыг хурааж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 54, 55, 56, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“54.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

55.Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглох бөгөөд зөрчвөл хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж зөрчсөн хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

56.Хандив өгөхийг хориглосон этгээд хандив өгсөн, авсан, хандив өгөхийг хориглосон этгээд болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

58.Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.6” гэснийг “мөн зүйлийн 6.8” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд “1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт 17.1 дүгээр” гэж, төслийн 2 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 42 дахь хэсгийг хасаж, төслийн 1

дүгээр зүйлийн “41” гэсний ард “42” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төсөлд дараах агуулгатай 3 дугаар зүйлийг нэмэх:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.8.9.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүгч харьяалан шийдвэрлэх Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаа, тагнуул, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх бүхий албан тушаалтан, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, татварын улсын байцаагч гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ес.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

С.Бямбацогт: Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханы гаргасан, Төслийн 30 дугаар зүйлд 30.8 дахь хэсэг нэмэх:

“30.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан үг хэлэв.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү “Авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлана.” гэсэн саналаа татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Эрдэнэбат, Л.Оюун-Эрдэнэ, Н.Энхболд нар үг хэлэв.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангийн гаргасан, “Эмэгтэйчүүдийн эсрэг Эрүүгийн хуульд заасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг, хүн амь, тагнуул, эх орноосоо урвах, авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	6
Бүгд:	12

53.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан үг хэлэв.

4.Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, М.Билэгт, Ц.Гарамжав, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Н.Оюундарь, Б.Саранчимэг, Ц.Цогзолмаа, Д.Оюунхорол, Б.Ундармаа, А.Ундраа, Д.Сарангэрэл нарын гаргасан, Төслийн “31.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна” гэснийг “31.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 30-иас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, О.Баасанхүү нар үг хэлэв.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, “Бүх шатны сонгуульд оролцохдоо өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд оролцох эрхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	9
Бүгд:	13

30.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, “Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар татагдсан нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн тохиолдолд сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 70.2 дахь хэсгийн “сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.” гэсний дараа “Мэдээлэл, технологийн багийн гишүүн, даамал нь санал авах тоолох төхөөрөмжөөс 4 метрээс багагүй зайд байрлаж, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж ажиллана.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Энхболд нар үг хэлэв.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу сонгогчдын нэрсийн жагсаалтын сонгогчийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг бүхий хэсгийг зөвхөн цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	11
Бүгд:	13

15.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж нар тайлбар хийв.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нарын гаргасан, “Нийт нэр дэвшигчийн 5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	3
-------------	---

Татгалзсан: 9
Бүгд: 12
25.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 31.2-ын “аль нэг хүйсийнх байна.” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 67.5 дахь хэсгийн “хийсний дараа” гэсний дараа “баруун долоовор хуруун дээр санал өгсөн гэсэн тэмдэглэгээ хийх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн тайлбар хийв.

12.Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.10-т “Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ.” гэснийг “Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн нам эвслээс гарсан хэдий ч 51 хувиас дээш тооны нам уг эвсэлд үлдсэн тохиолдолд тухайн эвсэл хэвээр хадгалагдана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Н.Энхболд, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Батзандан нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 3 цаг 27 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 19 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Гурав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулъя. Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн хийнэ.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүнээс 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Баасанхүү, Болд, Мөнх-Оргил, Нямбаатар, Оюунхорол, Содбаатар, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хуулийн төсөл нь 12 бүлэг 85 зүйлтэй бөгөөд ажлын дэд хэсгээс зарчмын зөрүүтэй 75 санал гаргалаа.

Ажлын хэсэг болон ажлын дэд хэсэг хамтран Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Цагдаагийн ерөнхий газар, Сангийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, хуульч, өмгөөлөгч нарын төлөөллийг оролцуулан нийт 3 удаа хуралдлаа. Ардчилсан намын зөвлөлөөс ирүүлсэн саналуудыг зарчмын зөрүүтэй саналуудыг томъёолол болгон авч үзэж, мөн Улсын Их Хуралд суудалгүй намуудын төлөөлөл саналаа биечлэн танилцуулж ажлын хэсгээр санал хураалгаж шийдвэрлүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Тогтохсүрэн даргад баярлалаа. Ажлын дэд хэсгийн нэрсийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Болдсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн захирал Эрдэнэбат, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн референт Бат-Эрдэнэ, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Нармандах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газрын дарга Ган-Эрдэнэ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Жавхлант, энэ хүмүүс байхгүй байна шүү.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчил шалгах мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга Лувсан-очир, Харилцаа холбооны зохицуулах хорооны Интернэтэд

суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Батболд, хууль, өмгөөлөгч Эрхэмбаатар гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гишүүдэд тараасан байгаа. Тэгээд хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Баасанхүү гишүүнээ тасаллаа. Д.Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Ажлын хэсэгт би орж ажилласан л даа. Тэгээд ажлын хэсэг дээр Ардчилсан намын нэлээн олон саналууд яг нэр дэвшигчид болон сонгогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс бол орсон. Бас нэлээн саналууд дэмжигдсэн гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Зарчмын хэд хэдэн саналууд манай санал унасан. Ардчилсан нам өнөөдрийн хүртэл холимог тогтолцоогоор явах нь зүйтэй. Сонгогчдын санал гээгдэхгүй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс энийг ярьсан.

Эрх баригчдын маань анхны оруулж ирсэн санал 26, 50 гэдэг бол үнэхээр хүлээж авах боломжгүй. 26 мандат дээр нэг хүнийг дугуйлах улс нэг тойрог гэсэн ийм зүйл оруулж ирснээсээ татгалзаж байгаа юм гээд. Тэгээд өнөөдрийн оруулж ирж байгаа энэ санал бас л томсгосон мажоритар хэлбэртэй боловч асуудлын шийдэл бол угаасаа биш гэж бид ингэж харж ажлын хэсэг дээр саналаа бол тодорхой илэрхийлсэн байгаа. Энэ бол 2008 оны томсгосон тойргоор явуулсан ийм жишиг дахин давтагдаж байгаа л даа. Түүх давтагддаг л юм байна.

Ардын нам намын дараа солиод шинэ намын даргатай орох үеийн сонгуулийн тогтолцоо, 2008 оны энэ тогтолцоо бол маш их тийм маргаантай, сонгуулийн үр дүн гарч байсан. Их будилаантай болж байсан. Энэнээсээ болж Монгол ардын хувьсгалт нам байраа шатааж байсан. Жагсаал цуглаан болж 5 хүний эрдэнэт амь сүйдэж байсан ийм л тогтолцоог бол өнөөдөр дахин сонгож байгаа.

Бид нар уг нь холимог хийгээд нээлттэй жагсаалтаар явуулаад бас ингээд нэг бүсчилсэн юм уу аймгаар нь хийе гэдэг саналыг ярилцсан боловч энэ бүр явахгүй нь л дээ. Тэгэхээр энэ бол асуудлын шийдэл биш байна гэж бид ингэж харж байгаа. Тийм учраас эрх баригчид энийгээ нэг эргэж харж болдоггүй юм уу? Одоо энэ бол олон сөрөг үр дагаврыг дагуулна. Сонгуулийн үр дүнг легитим чанарыг үнэхээр хангаж чадахгүй. Дотоодын өрсөлдөөн сэргэлдөөн намуудын доторх өрсөлдөөн сэргэлдөөн нэмэгдэнэ. Сонгогчдын санал өөрөө бүтэн бас тусгагдаж чадахгүй. Жижиг намуудыг сонгох боломж хумигдана. Сонгогдсоны дараа ч гэсэн одоо тойргийн эрх ашиг гэж хаягдахгүй шүү дээ. 1 аймаг, 1 тойрог л юм чинь хэвээрээ үлдэнэ. Гэх мэтээр олон сөрөг үр дагавар бол гарна гэж бид ингэж хараад байгаа юм.

Тийм учраас бол энэ дээр нэг эргэж ярих зайлшгүй шаардлага үүсэж байна уу гэдгээ би бас давхар хэлмээр байна. Түүнээс гадна бас зарчмын 2 санал дээр бид бас энэ дээр ажлын хэсэг дээр бас дэмжлэг авч чадсангүй. Энэ бол сонгогчдын нэрсийн жагсаалтыг урд талын хуулиар нам эвслүүдэд өгч болж байсныг бол болиулсан. Би бол энэ дээр бол бас хардалт яваад л байгаа. Тийм учраас одоо манайхан бол зарчмын зөрүүтэй санал энэ дээр дахиж гаргах нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа. Энийг заавал яагаад ингэж хязгаарласан юм бэ гэж.

Дараагийн нэг санал нь болохоор унасан санал бол сонгогч саналаа өгснөө бол заавал мэдэгдсэн ийм тэмдэглэгээг хуучин бид нар долоовор хуруу дээрээ

тэмдэг тавьж байсныг хийх шаардлагатай. Олон газар давхар санал өгөх магадлал бол урд нь бол гарч байсан бол зарим нэг зүйл байна. Нотлогдсон. Энийг бид нар давтаж болохгүй гэж. Энэ санал бас унасан. Ингээд базаад үзэхэд Ардчилсан намын тавьсан 3 зарчмын санал уначхаад байна л даа. Тэгээд энэ дээр бол одоо ямар бололцоо юу байна вэ энийг нэг эргэж харж бүгдээрээ ярилцах боломж байна уу, үгүй юу гэдэг дээр бол би энэ холбогдох хүмүүсээс бол зайлшгүй асуух шаардлагатай гэж ингэж үзсэн. Тиймээс хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Д.Тогтохсүрэн: Тодорхой асуудлууд хөндлөө. Ардчилсан намаас нийт 18 санал тавьсан. Үндсэндээ 15 орчим санал нь тусгагдсан. Саяын хэлж байгаа 3 саналыг бол ажлын дэд хэсэг, ажлын хэсэг боломжгүй гэж үзсэн юм. 1 дүгээрт бол сонгогчдын нэрсийн жагсаалтыг хувилж өгдөг бол яагаад ч болохгүй. 2018 онд батлагдсан энэ Улсын бүртгэлийн 3 хуулиар бол энэ хориотой. Иргэний мэдээллийг хэн нэгэн өөр нэг этгээд иргэний мэдээллийн нууцад нэвтэрч болохгүй гэж байгаа юм. Тийм. Өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр. Тэгэхээр намууд ингээд авчхаж байна гэдэг чинь өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр мэдээллийг нь авчхаж байгаа юм.

Энийг бол энэ иргэний бүртгэлийн хуулиар нь өөрөөр нь хориотой байгаа юм. Тийм учраас бол манай улсын бүртгэлийн байгууллагаас энэ заалтыг оруулах боломжгүй. Хүний хувь нууц хувь хүний нууцад халдаж байгаа асуудал гэж үзэж байгаа. Иргэд өөрсдөө дургүйцдэг юм байна лээ. Иргэд өөрсдөө дургүйцдэг юм байна лээ. Өмнөх сонгуулиудын үед манай Сонгуулийн ерөнхий хороо хэлж байгаа юм. Өмнөх сонгуулиудын үед намын одоо сонгуулийн ажилтан ч юм уу, ухуулагч юм уу хувь хүний регистр, нэрийг бариад явахаар иргэд аягүй дургүйцдэг. Миний энэ хувийн мэдээллийг хаанаас олсон бэ, яаж олж авсан бэ? Яагаад миний мэдээлэл хүний гарт очсон байдаг юм бэ эд нар гээд. Иргэдийн хувьд бол аягүй их хэл ам гардаг ийм асуудал байгаа юм.

Тийм учраас бол оруулах боломжгүй гэж байгаа юм. Би энэ асуудлууд дээр манай Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга би нэмэлт тайлбар өгөх болов уу гэж бодож байна.

2 дугаарт нь тэр тэмдэглэгээтэй холбоотой асуудлаар бол бас ярилцсан. Паспорт буюу иргэний үнэмлэх дээр бол дардас дарах ямар ч боломжгүй гэж байгаа юм. Энэ хуулиар хориотой юм байна лээ. Гарын одоо долоовор хуруун дээр тэмдэглэгээ бэхээр тэмдэглэгээ хийдэг байсан. Энийг бол одоо бол 1 дүгээрт бол бэх нь ч олддоггүй юм байна. 2 дугаарт хувь хүн ч бас дургүйцдэг юм байна. Тэмдэглүүлээ гэж. 3 дугаарт бол нөгөө хурууны хээний давтагдашгүй өгөгдөл орсон учраас ямар ч иргэн хүн давхардаж санал өгөх ямар ч боломжгүй гэж байгаа юм Улсын бүртгэлийн байгууллага.

Тийм учраас бол энэ 3 саналыг бол одоо авах боломжгүй гэж ажлын хэсэг, дэд хэсэг үзсэн юм. Тэгээд манай улсын бүртгэлийн байгууллага энэ дээр би нэмэлт тайлбар өгөх болов уу гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Саяын асуудлууд дээр улсын бүртгэлийн ерөнхий газар, шаардлагатай бол Сонгуулийн ерөнхий хорооноос нэмээд хариулъя даа. Тодотгоод. Эхлээд Улсын бүртгэлийн газар хариулъя.

Б.Баасандорж: Баасандорж Улсын бүртгэлийн ерөнхий газар. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулахад өргөн мэдүүлэхэд бол сонгуульд оролцож байгаа намуудад хуучин бол нэрсийн жагсаалт өгдөг байсан. Энэ заалтыг бол хасаж өргөн мэдүүлсэн. Яг ажлын дэд хэсэг дээр ярьж байгаад Сонгуулийн ерөнхий хороонд бол нэгт бол иргэдээс маш их гомдол ирж байсан. Яг хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл их задарч байна гэдэг байдлаар.

2-т нь 2018 оны 6 сарын 21-ний өдөр бүртгэлийн багц хуулийг баталж өгсөн. Өмнөх хуулиудаар бол иргэдийн ямар мэдээлэл нь нээлттэй юм, ямар мэдээлэл нь хаалттай байдаг юм, ямар хязгаартай байдгийг нь хуульчилж өгөөгүй байсан. Энэ багц хуулиар бол иргэний тодорхой мэдээлэл нь хаалттай байна. Иргэний ямар мэдээлэл нь хязгаартай байх юм бэ? Хязгаартай мэдээллийг зөвхөн иргэн нэгт өөрийнх нь зөвшөөрснөөр өгнө. Хоёрт шүүх, прокурорын байгууллагад өгнө гэсэн хуулийг хуульчилж өгсөн байгаа.

Энэ утгаараа яг энэ намуудад нэрсийн жагсаалт дээр бол гэрийн хаяг, тэр иргэний хувийн мэдээлэл байдаг. Энэ үүднээсээ энэ хуульдаа нийцүүлж бүртгэлийн багц хуульдаа нийцүүлж мөн иргэдээс ирсэн гомдлуудыг Сонгуулийн ерөнхий хороон дээр судалж үзсэний үндсэн дээр энэ хууль хоорондын нийцлийн үүднээс энийг бол хассан байгаа төслөөс.

С.Бямбацогт: Тэр тэмдэглэгээ. Нэмээд Сонгуулийн ерөнхий хороо. 5 номерын микрофон.

Ч.Содномцэрэн: Энэ хуруун дээр хийдэг бэхэн тэмдэглэгээг 3 шалтгааны үүднээс бол боломжгүй гэж үзсэн. 1 дүгээрт бол энэ бэхийг хийдэг үйлдвэр Энэтхэгт байдаг жижигхэн үйлдвэр байсан байна. Тэгээд бид 17 оны сонгуулиар авах гэтэл бол үйлдвэр нь хаагдсан гэсэн нэг ийм хариу бидэнд өгсөн.

2 дугаарт бол онгоцоор бол ийм төрлийн бодисыг тээвэрлэхийг хориглосон юм байна. Олон улсын юугаар. 3 дугаарт бол тэмдэглэгээний явцад бол маш их гомдол гарсан. Одоо харшилтай улсуудад бол реакци үзүүлж байна. Мөн хэд хэдэн хүн бол түлэгдсэн энд. Бүр зарим нь бол маш хүнд түлэгдсэн зураг юугаа аваад баталгаажуулаад Сонгуулийн ерөнхий хорооноос нөхөн төлбөр авсан. Бид энийг нь бол нөхөн төлбөрийг нь олгосон. Тэгээд энэ бэхийг бол ер нь яагаад тэр үйлдвэр нь хаагдсан юм бэ гэхээр Афганистан, Монгол хоёр л авдаг байсан юм байна. Тэгээд Афганистан авахаа байсан. Монгол Улс 8 оноос хойш авахаа байсан учраас бид энэ бэхийг үйлдвэрлэхээ байсан. Тийм учраас нийлүүлэх боломжгүй гэсэн ийм хариу өгч байсан юм.

С.Бямбацогт: Тэр нэг асуулт үлдчихлээ л дээ бас. Эргэлзээтэй, иргэний үнэмлэх дээр тэмдэглэгээ хийж болохгүй юу. 2 дугаарт нь бас давхар санал өгөх бололцоо боломж байгаа юм уу, байхгүй юм уу тийм ээ? Тэгээд энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөхгүй бол Сонгуулийн хууль дээр одоо юу гэдэг юм эхнээсээ жаахан буруу мессеж, буруу ойлголт өгөөд явчих юм бол мушгиад л явчихдаг. Тийм болохоор бас зөв ойлголт хоёрдмол салаа утгагүй маш тодорхой тийм хариултууд хэрэгтэй байна л даа.

Давхар санал өгөх бололцоо бий юу, байхгүй юу? Энэ дээр одоо давхар санал байхгүй бол байхгүй гэдгээ тодорхой хэлье. 3 номер. Улсын бүртгэлийн ерөнхий газар.

Б.Баасандорж: Баасандорж. 2012 оны сонгуулиас эхэлж бол Монгол Улсад бол иргэний сонгуулийг өгөхдөө биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээгээр өгдөг болсон. Заавал иргэн очихдоо иргэний үнэмлэхээ шалгуулдаггүй. Биеийн давхцахгүй өгөгдлөөрөө өөрийгөө таниулаад өөртэй нь холбоотой мэдээлэл гарч ирээд сонгуулиа өгдөг. Яг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 89.4 дээр ямар тохиолдолд иргэний үнэмлэх хэрэглэх вэ гэдгийг бол нарийн зохицуулж өгсөн байдаг. Энэ нь гарын хурууны хээ шалгах автомат төхөөрөмж ажиллахгүй буюу ажиллах боломжгүй болсон түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн тухайд иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж сонгогчийн бүртгэлийн хуудас олгож болно гэж.

Өөрөөр хэлбэл сая Содномцэрэн даргын хэлснээр нөгөө гарын хурууны хээ хүмүүсийн гарын хурууны хээнүүд янз бүрийн тохиолдол шалтгаанаар өөрчлөгддөг. Энэ тохиолдолд бол иргэний үнэмлэхийг ашиглана шүү. Хүндэтгэн үзэх шалтгаантай тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бол мөн иргэний үнэмлэхийг ашиглана шүү. Бусад тохиолдолд биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээгээрээ иргэдийг таниад сонгууль өгөх боломж нөхцөлөөр нь хангаж байгаа.

Нэг хүн 2 удаа санал өгөх бол ямар ч боломж байхгүй. Биеийн давхцахгүй өгөгдлөөрөө дахин өөр газар өгөх ямар ч боломж байхгүй. Хуулиараа, мөн технологиороо. Манай энэ бүртгэлийн систем өөрөө тагнуулын хяналт дээр тагнуулын систем дээр явдаг. 2 удаа өгөх асуудал бол байхгүй байгаа. Боломжгүй.

С.Бямбацогт: Баасанхүү гишүүн асуултаа асууя.

О.Баасанхүү: Энэ ажлын хэсэгт яагаад энэ юу ороогүй юм бол? Прокурорын байгууллагаас. Эсхүл АТГ-аас яагаад ороогүй юм бол гэж. Сая энэний өмнө жишээлбэл гэм нүгэлгүй болъё. Бид нар бузар булай хүмүүс учраас нэг өдөр ч гэсэн ариун цагаан байя гээд хууль баталж байсан. Гэм гэдгийг би юу гэж ойлгох вэ гэхээр өөрөө хулгай хийхээс гадна хулгайчийг дэмжиж болохгүй гэж ойлгоод байгаа юм л даа. Тэгээд энэ удаагийн хууль дээр ингээд харахаар 3 ерөөсөө асуудлыг шийдээгүй байна л даа. 1 дүгээрт нь авлига албан тушаалын хэргээр ял эдэлдэг хүмүүс төрийн албанд орно гээд гүйгээд байдаг. Шүүхээр ял эдэлсэн хүмүүс. Тэрийг би хувьдаа юу гэж ойлгож байгаа вэ гэвэл Төрийн албаны тухай хуулийн зайлшгүй зарчим дээр бол албан тушаалын болон авлигын хэргээр ял эдэлсэн бол төрийн албанд орохгүй гээд заасан мөртөө Сонгуулийн хууль дээр бол болно гээд ингээд заачихсан байна.

2 дахь миний асуулт бол юу вэ гэх юм бол прокурорын байгууллага өнөөдөр одоо юу гэдэг юм тодорхой хэргүүдийг шүүх рүү шилжүүлэх гэхээр одоо ингээд Их Хурлын гишүүн болоод тэндээ яс очоод суучихна. Тэгээд хөөн хэлэлцэх хугацаагаа одоо та бүхэн 8 жил болгосон учраас автоматаар өнөөдөр юу вэ гэх юм бол тэр хөөн хэлэлцэх хугацаагаа хүлээлгэхэд Их Хурлын гишүүн болох гээд байна. Томсгосон тойрог гэдэг чинь ерөөсөө л тэр шүү дээ. Намдаа хайртай бол нэгийг дугуйлаарай. Намайг дугуйлахгүй байж болно. Намаа дугуйлаарай гэж байгаад л яаж ийж байгаад тоон дотор үсэг гээд 6-н 1 болж орж ирэх гээд л сууж байгаа.

Тэгэхээр энэ прокурорын байгууллагын Улсын ерөнхий прокурор нь Улсын Их Хуралд эрхийг түдгэлзүүлье гэж ордог шиг. Сонгуулийн хороонд яагаад өнөөдөр юу гэдэг юм энэ хүмүүс бол одоо орж болохгүй. Энэ бол яллагч сэжигтэн яллагчаар татагдсан. Тийм учраас энэ удаа түр боль. 4 жил дотроо бол хойшоо байж байгаад гэм буруугүй гэдгээ тогтоолгоод дахиад орж болно гэдэг эрхийг нь яагаад нээж өгөхгүй. Өнөөдөр заавал нэг шүүхийн гээд ингээд байгаа юм бэ гэж.

Гуравт нь миний бас нэг гайхаад байгаа зүйл бол энэ дахиад л нөгөө авлига албан тушаалтайгаа холбоотой л доо. Тэр нь юу вэ гэх юм бол сонгуулийн үед ингээд баахан хүнийг ингээд юу яачихдаг. Одоо өөрөө болон өрөөл бусдаар мөнгө тараачихдаг. Шүүхийн юмаар явдаг. Хөөрхий тэгээд муу нэртэй луу данстайгаараа нөгөө муу ажилчид нь очоод хэрэг төвөгт орчихдог. Заримдаа өөрөө ч гэсэн янз бүрийн юун дээр энэ сонгуулийн зөрчсөн нь үнэн байна гэдэг. Тэгээд одоо Их Хурлын гишүүний дархан эрхээр ингээд одоо үлдсэн байгаа юм.

Тэгэхээр ер нь бол дараагийн сонгууль дээр ч тэр одоогийн сонгууль дээр ч тэр өмнөх сонгууль дээр ч тэр сонгуулийн хууль зөрчсөн хүнийг яагаад оруулъя гээд байгаа юм бэ? Шүүхээр тогтоогдсон хүнийг оруулахгүй байж болдоггүй юм уу? Шүүхээр тогтоогдсон. Бүх шатны сонгууль дээр. Тэгээд яах вэ тэр бид одоо жишээлбэл яах вэ энд байгаа хүмүүс тогтоогдоогүй л гэж бодъё л доо. Тийм хүмүүс яах вэ одоо тэгээд одоо бид нар аюултай юм байна. 24 ч гэдэг юм уу цаашаагаа аюултай юм байна. Тийм учраас өөрийнхөө ажилчид болон өөрөө анхааръя гэж болдоггүй юм байна.

Тэгэхээр ийм ер нь энэ хуулийг яг горимын зарчмын юу өөрчлөөд байгаа юм бэ? Гурвуулаа хөөрхий хийсэн бол. 30 хувийн эмэгтэйчүүдийг оруулъя гэж байгаа юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн квот яагаад оруулж болдоггүй юм бэ? Та нарт мессеж ирсэн л байлгүй дээ. Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг чинь сохор доголлон гэсэн үг биш шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг чинь сая тэр Болороо гээд нэг бүсгүй гарч байна. Дээд сургуульд боловсрол эзэмшсэн. Сүрхий л хүн байна лээ шүү дээ. Харин биднээс ч илүү өнөөдөр юу гэдэг юм ждү есөн шидийн шуналгүй. Харин өөрсдийнхөө юмыг ингээд гаргаад ярьчихмаар байгаа юм.

Тэгэхээр энэ квотыг яагаад оруулж болдоггүй юм бэ? Энэ квотыг яагаад оруулахгүй байгаа юм бэ? Бусад оронд Японд жишээлбэл хараагүй хүн өнөөдөр Их Хурлын гишүүн хийж байна, Солонгост сонсголгүй хүн өнөөдөр Их Хурлын гишүүн хийж байна. Энэ Их Хурлын гишүүн гэдэг чинь бүх хүмүүсийн төлөөлөл гэж би ойлгож байгаа шүү дээ. Яагаад ийм квот оруулахгүй байгаа юм бэ? 200 мянга гаруй хүн өнөөдөр ямар нэгэн байдлаар байж байна шүү дээ. Тийм ... /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? Тэр шүүхээр ял шийтгэлтэй нь тогтоогдсон бол нэг дэвшүүлэхгүй байх ёстой байсан. Яллагдагчид сэжигтэн яллагчийг нэр дэвшүүлэхгүй байх бололцоотой ийм заалтууд оруулмаар байна. Яагаад оруулахгүй байгаа юм бэ? Тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ яагаад тийм квот тогтоохгүй байгаа юм бэ гэсэн асуултууд асуугаад байна шүү дээ. Хэн хариулах юм бэ? Цагдаа. Нямдаваа. Хэддүгээр микрофон бэ? 7 дээр. Эрдэнэбатын юун дээр яачих. Эрдэнэбатаа.

Л.Нямдаваа: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн ерөнхий газар Нямдаваа. Хуулийн төсөл дээр болохоор 30.7 дээр бол ийм томъёолол орж ирсэн анх. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно

гэсэн. Нэр дэвшигчид тавих ерөнхий шаардлага бол тавьсан байдаг. Ажлын хэсэг Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу энэ эрүүгийн хариуцлага гэдэг ойлголт нь өөрөө өргөн хүрээтэй ойлголт юм байна. Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг дээр болохоор эрүүгийн хариуцлага нь ял албадлагын арга хэмжээнээс бүрдэх юм байна. Ял нь бол 5 төрлийн ял байна. Албадлага нь бол албадлагын арга хэмжээний төрөлд нь бол үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ гээд их өргөн хүрээтэй орчих юм байна гэж үзээд чиглэлийн дагуу бол бид нар 30,7 дахь хэсгийг шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ял эдэлж байгаа хүн гэдэг байдлаар нэр дэвшихийг хориглоно гэж оруулж өгсөн.

Авлига албан тушаалын хэргийг бол хууль санаачлагчийн зүгээс бол төсөл дээр тусгаагүй байсан.

С.Бямбацогт: Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Бид нар ингээд зурагт харахаараа бүгдээрээ шударга болчихдог. Ёстой авлигатай тэмцье, хулгайчтай тэмцье гээд байдаг хэр нь Сонгуулийн болохоороо өнөөдөр юу гэдэг юм бодитой өөрчлөлтүүдийг ерөөсөө санал болгосон юм байхгүй. Одоо хөөн хэлэлцэх хугацаагаар өчнөөн хүн цагаадах гээд байна. Яана ийнэ гээд яриад л байна шүү дээ. Тэд нарыгаа яагаад block-лож болохгүй байгаа юм бэ? Дээрээс нь өмнө нь өчнөөн л хүмүүс ял эдэлсэн хүмүүс байна шүү дээ. Авлига албан тушаалаар бүгд одоо юу гэдэг юм нүүрээ хувиргаад зүсээ солиод ороод ирэх гээд байна шүү дээ.

Дээрээс нь өмнө нь одоо 7 удаагийн сонгуулиар будилаан хийгээд шүүхээр тогтоогдсон. Ямар ч үр дүн байхгүй. Дахиад л өөр аргаар ямар харин ч арга нь нарийсаад хулгай нь нарийсаад гэдэг шиг наад сонгуулийг чинь будилаантуулах гээд байна шүү дээ. Тийм нөхөд мэргэшсэн хулгайч гэдэг шиг өнөөдөр мэргэшсэн тэр будилаантай хүмүүсийг яг ямар хуулийн ямар заалтаар одоо хязгаарласан бэ? Энийг нэг тодруулж өгөөч.

С.Бямбацогт: Нямдаваа. Сонгуулийн ерөнхий хороо. 5 дугаар микрофон.

Ч.Содномцэрэн: Баасанхүү гишүүний асуултад хариулъя. Ер нь бол одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Сонгуулийн тухай хуульд бол ял шийтгүүлж байгаагүй гэсэн ийм заалт байгаа юм. Ял шийтгүүлж байгаагүй. Ял шийтгүүлж байсан бол ялгүй болсон байх ялгүйд тооцогдсон байх гэсэн ийм заалт байсан юм. Энийг бол улс төрийн намуудтай энэ Сонгуулийн тухай хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж байхад шүүмжилсэн. Яагаад өмнө нь бол ял эдэлж байсан. Тэгээд одоо ялынхаа хугацааг дуусгаад ингээд цагаадсан хүн яагаад сонгуульд өрсөлдөж болдоггүй юм бэ? Та нарын энэ заалт чинь их хатуу заалт байна гэсэн ийм шүүмжлэлүүд гарч байсан.

Үүний дагуу бол бид нар ажлын хэсэг дээр ярилцаад ер нь өмнө нь ял шийтгүүлж байсан хүмүүс бол тэгээд хугацаа нь дуусаад ялгүйд тооцогдоод цагаадсан бол сонгуульд оролцуулъя. Энэ хуулийнхаа төсөл дээр бол ял .../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн цагийг сунгая. Хариулт авах 5 дугаар микрофон.

Ч.Содномцэрэн: Ийм учраас бол ял эдэлж байгаа хүнийг бол дэвшихийг нь бол хориглоё. Өмнө нь ял эдэлж байсан улсуудын тэр хугацаа нь дуусаад цагаадсан бол одоо энийг нь оролцуулъя гэсэн ийм зүйлийг ажлын хэсэг дээр яриад оруулсан юм.

С.Бямбацогт: Хууль санаачлагч бас хариулах ёстой байгаа шүү. Хариулт байхгүй юу тийм ээ? Зарчмын хуулийн төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд асуултаа асууж дууслаа. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналаа гишүүд бас наашаа өгч байж болно шүү. Эхлээд ажлын хэсгийн саналаар санал хураалт явагдана. Араас нь гишүүдийн саналаар санал хураалтууд явагдана. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно.” Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар дэмжлээ энэ санал.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Баасанхүү гишүүн санал хураалтыг цуцалъя. Баасанхүү гишүүн асуултаа асууж, саналаа хэлье.

О.Баасанхүү: Тэгэхээр ингэж би ойлгоод байгаа юм. Монгол Улсын Үндсэн хууль дээр мэдээж олон мандаттай тойргоос дэвшихээс өөр аргагүй. Олон мандат гэдгээ юу гэж ойлгох вэ гэдгийг бол би ойлгохдоо 2 буюу түүнээс дээш одоо 76 гишүүн маань бол тойрогт орох нь ойлгомжтой. Хамгийн нь гол нь яг 26 гэдэг хамаагүй шүү дээ. Яагаад бүсчлээгүй нэг улс, нэг тойрог ч гэдэг юм уу хийж болоогүй юм бэ гэж би гайхаад байгаа байхгүй юу. Энийг би сонгуулийн хорооноос асуумаар санагдаад байгаа юм.

Яагаад гэхээр энэ 26, 50 гэдэг чинь 26 маш буруу гээгүй байна шүү дээ. 26 зөв гэж байгаа юм. Хамгийн гол 1-26-аараа эрэмбэлж болдоггүй юм уу гэдэг дээр л маргаан үүссэн болохоос нэгт орсон хүний араас тэр байгаа 900-д орсон хүн суганд нь хавчуулагдаж гулсаж болохгүй гэдэг дээр маргаан үүссэн шүү дээ. Тэгэхээр юмыг ингэж хоёр туйл руу шиддэгээ боль л доо. Нэг туйл дээрээ нэг талдаа байж болдоггүй юм уу? Өөрөөр хэлэх юм бол миний ойлгож байгаагаар олон мандаттай байна. Тойрог бол Монгол Улс нэг тойрог байна гэж яагаад хэлж болдоггүй юм бэ? Монгол Улс нэг тойрог олон мандаттай. 76-уулаа Монгол Улсын хэмжээнд яагаад өрсөлдөж болдоггүй юм бэ? Тэгээд эхний 76-г л сонгоё л доо. Эхний 76-г яагаад сонгож болдоггүй юм бэ? Хамгийн өндөр оноо авсан нь магадгүй 50 юм уу 60 оноо авсан гэж бодоход хамгийн бага оноо авсан нь одоо 76 дахь хүн нь хэд ч байдаг юм. 20 юм уу, 8 юм уу, 9 хувийн санал авсан байж болно шүү дээ.

Тэгээд эхний 76, шилдэг 76-аагаа яагаад бид нар сонгож болохгүй заавал нөгөө 2008 он руугаа явах гээд байгаа юм бэ? Хэрэв ингэх юм бол нам гэдэг

ойлголт чинь маш тодорхой болно шүү дээ. Нам ялахын төлөө явах уу гэдгээрээ тэр Монгол Улсын хэмжээд яв. Тэгэхгүй болохоор аймаг дотроо нөхөд бол хоорондоо мууддаг тэгдэг гээд та нар чинь шившгээ хутгаад байгаа биз дээ. Хамгийн их зовлон амсдаг манай Ардчилсан нам хэлээд байна шүү дээ. Бид нар ёстой зодолддог юм, мууддаг юм, бие биеийнхээ араас хутгалдаг юм. Аймшигтай юм болдог юм. 2008 оны аймар юм болсон шүү дээ гээд л. Ийм юм зовлон яриад байхад нь энийг яагаад сонгууль дээр оруулж ирээд зарчмын хувьд шийдэж болдоггүй юм бэ?

50 жижиг 26 одоо юу гээд Монгол Улсын хэмжээнд байсан. Тэгвэл 76 Монгол Улсын хэмжээнд гэхдээ гулсахгүй. Гулсахаараа л зөрчөөд байна шүү дээ. Тэгээд Монгол Улс даяараа Дорнодод байгаа хүн намайг сонгомоор байна шүү дээ. Увсад байгаа хүн сонгомоор байна шүү дээ. Ховдод байгаа хүн сонгомоор байна шүү дээ. Би ч гэсэн бас тэд нарын санал авмаар байна шүү дээ. Тэгээд Монгол Улсын хэмжээнд тэр байгаа энэ гадаадад байгаа 200 мянган Монголчууд ч бас сонгомоор байна шүү дээ. Ингэж болдоггүй юм уу? Энэ дээр нэг тайлбар өгөөч. Заавал энэ тойргоо ингэж 26 болгох шалтгаан нь юу юм бэ?

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Сонгуулийн ерөнхий хороо, 5 дугаар микрофон.

Ч.Содномцэрэн: Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурал хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль батлах онцгой бүрэн эрхтэй. Энэ бүрэн эрхийнхээ хүрээнд Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг гараад ажилласан. Энэ бүрэн эрхийнхээ хүрээнд би энэ тогтолцоог ингээд оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Энэ бол өмнө нь бол 2 удаагийн сонгуульд хэрэглэж байсан тогтолцоо. 1992, 2008 онд хэрэглэж байсан тогтолцоо. Тийм учраас бол энэ бол энэ тогтолцоогоор явахад бол болохгүй юм байхгүй гэж үзэж байгаа. Ийм л тийм. Өмнө нь яваад 92 оны анхны сонгуулийг энэ тогтолцоогоор хийсэн. 8 онд дунд нь нэг хийсэн. Болсон.

76 гишүүнээ сонгосон. Тийм учраас бол Сонгуулийн ерөнхий хорооны хувьд бол энэ тогтолцоо бол өмнө нь хэрэглэж байсан учраас хэрэглээд явахад болохгүй зүйл байхгүй л гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Санал хураалт явуулъя. 2 дугаар санал. 2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дээрх санал дэмжигдсэн тохиолдолд дараах одоо 3-5 дахь саналыг хураана. Яагаад гэвэл шууд уялдаж байгаа учраас. Та бүхэнд саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

3.Төслөөс 18 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3, 21 дүгээр зүйлийн 21.11, 60 дугаар зүйлийн 60.2, 60.5, 63 дугаар зүйлийн 63.2, 63.4, 66 дугаар зүйлийн 66.16, 66.17, 66.18, 68 дугаар зүйлийн 68.15, 68.16, 68.17, 68.18, 72 дугаар зүйлийн 72.19, 72.20, 72.21, 76 дугаар зүйлийн 76.6, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.4.3 дэх заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойргоос сонгогдсон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийн “болон төв комиссын

дарга” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “, 22” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг, 76 дугаар зүйлийн 76.7 дахь хэсгийн “Энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг, 78 дугаар зүйлийн гарчгийн “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх,” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг тус тус хасах, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал явж байгаа. 4.Төслийн, санал гаргасан ажлын хэсгийн гишүүд санал гаргасан байгаа. Тийм түрүүн Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг. Би мэдээлэл бас өгье.

Улсын Их Хурлын даргын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 246 дугаар захирамжаар ажлын хэсгийн ахлагчаар Сонгуулийн хуулийн ажлын хэсгийн ахлагчаар Тогтохсүрэн гишүүн ахлагч, Баасанхүү, Болд, Мөнх-Оргил, Нямбаатар, Оюунхорол, Содбаатар, Н.Энхболд, Д.Эрдэнэбат гэсэн одоо гишүүд ажлын хэсгийн гишүүд ажиллаж байгаа. Тэгээд энэ саналыг одоо ажлын хэсэг буюу энэ гишүүд гаргаж байгаа гэдгийг бас та бүхэнд бас танилцуулъя. 4 дүгээр санал.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг “нэр дэвшигчийг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “Сонгуулийн хороодод” гэж, 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага” гэснийг “Сонгуулийн хороод” гэж, 20 дугаар зүйлийн 20.19 дэх хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын” гэснийг “Сонгуулийн хороодын” гэж, 20 дугаар зүйлийн 20.20 дахь хэсгийн “байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “сонгуулийн хороонд” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн доор дурдсан зүйл, хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг:

“14.1.Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороог нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон хэсгийн хороо нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид “сонгуулийн хороод” гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.”

Төслийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.”

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Нам, эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлнэ.”

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:

“32.1.Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн бие даан нэр дэвшиж болно.”

Төслийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг:

“67.2.Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.”

Төслийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг:

“73.1.Тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.”

Төслийн 75 дугаар зүйл:

“75.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.

75.2.Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

75.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.

75.4.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.”

Төслийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг:

“78.1 .Энэ хуулийн 4.3.3-т заасан үндэслэлээр нөхөн сонгууль явагдана.” Гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор саналыг. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“18 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

“25 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;”

гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “иргэний улсын бүртгэлийн биеийн давхцалгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дугаар авсан эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9 дэх заалт нэмэх, хуулийн нэр томьёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.8.“Цахим хуудас” гэж бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг;

3.1.9.“Ял эдэлж байгаа” гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үнсдэн болон нэмэгдэл ялаа эдэлж дуусаагүй, эсхүл торгох ялыг биелүүлээгүй байхыг ойлгоно.” Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Энэ цахим хуудас гэж нэг юм яриад байна. Бүх төрлийн контентыг, интернэт, домэйн нэр болон цахим орчин олон нийтийн сүлжээг хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг гээд. Гэтэл яг одоо өнөөдөр интернэт гээд байгаа одоо интернэт гэдэг чинь энэнээс шал өөр шүү дээ. Ямар нэгэн домэйн ашиглаагүй тэгээд л facebook дээр нэг өөрийн нүүр амаа нуугаад л хийдэг шүү дээ. Утасны яриа одоо жишээлбэл миний мэдэж байгаагаар одоо тэр Дорноговийн Гантулга гээд залуу миний яриаг бичсэн гэж одоо Батзандан надад хэлж байна л даа.

Хоорондоо нэг би цаадхыг чинь жаахан ярьсан байгаа юм. Тэгээд сонгуулиар тэрийг ашиглана гэж ярих юм шиг байгаа юм. Би бол тэр хүний шалдан зургийг нь би олон нийтэд дэлгэхгүй гэж одоо тэр хүнтэй ярьж байгаа. Гэх мэт ингээд сонгуулиар бид нарын хооронд бол цус асгараагүй алалцаан болно л доо. Тэгэхээр иймэрхүү юмнуудаа зохицуулж чадсан уу гэдгийг би мэдмээр байгаа байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт би юу гэж хэлэх гээд байгаа вэ гэхээр тэр ял эдэлж байгаа гээд нэг юм яриад байгаа юм. Ял эдэлж байгаа гэдгээ би юу гэж ойлгож байгаа вэ гэхээр бол шоронд ч байдаг юм уу эсхүл тодорхой хугацаатай яриад байдаг. Гэтэл ялаас хамаарахгүй тэр авлига албан тушаалын хэргийг яриад байна шүү дээ. Бид нар одоо энэ Авлигатай тэмцье гэж яриад байгаа биз дээ. Төрөө цэвэр болгоё ариун болгоё төрөө хулгайлдаггүй болгоё хулгайч хүмүүсийг хол болгоё гээд л энэтэй одоо надтай бүгд санал нэг байж яагаад өнөөдөр ингээд авлига албан тушаалыг болохоор дэмжээд байгаа юм бэ?

Энэ чинь одоо ялаас хамаарахгүй ойлголт. Зүгээр л хар тамга дарсан шүү дээ. Бид одоо жишээлбэл Япон виз өгдөггүй шүү дээ. Захиргааны зөрчил гаргасан бол улсдаа оруулахгүй гээд ямар ч виз өгдөггүй. Та өөрийнхөө улсдаа захиргааны зөрчилтэй юм байна гэж. Юун шорон бол 2 дугаар асуудал. Америк бол ийм

авлига албан тушаалын хэрэг дээр виз өгдөггүй. Манайх авлига албан тушаалтай хүмүүсийг оруулахгүй нутагтаа гээд. Монгол болохоор бол төрдөө оруулъя. Тухайн үедээ алдсан юм, сандарсан юм, болгоомжилсон юм гээд. Одоо жишээлбэл миний мэдэж байгаагаар Баатар гэдэг хүн одоо өнөөдөр байж л байна шүү дээ. Юуны ч гэнэ вэ одоо уг нь гаалийн Баатар гээд алдартай авлигын хэрэг байсан. Одоо төрийн албанд орсон тансаглаад л сууж байна.

Тийм хүмүүсийг өнөөдөр энэ хууль тогтоохынхоо толгой дээр тавьж болж байгаа юм уу? Энийг болиулъя гэж ярьж болохгүй юм уу? Тэгэхээр нэг ийм одоо энэ 2 зүйлийг зохицуулж чадах уу, чадахгүй юу гэдгийг л би асуумаар байна шүү дээ. Тийм.

С.Бямбацогт: 1 дүгээр асуулт тэр цахимтай холбоотой асуултад Лувсан-Очир дарга, 1 дүгээр микрофон хариулъя. 2 дугаар асуултад хууль санаачлагч, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

А.Лувсан-Очир: Харилцаа, холбооны зохицуулах хороо Лувсан-Очир. Цахим хуудас гэдгийг тодорхойлохдоо энэ бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр гэж байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө домэйн нэр ашиглахгүйгээр зүгээр facebook-р ороод байна гэж байгаа. Ингэхээр өөрөө бол энэ интернэт дээр домэйн нэрийг яаж ашиглах вэ гэхээр facebook.com гэдэг бол өөрөөр хэлбэл домэйн нэр байгаад байгаа юм. Энэ домэйн нэр гэдэг энэ нэр томьёоны тодорхойлолтыг бид нар Харилцаа, холбооны тухай хуулиасаа ишилж авсан байгаад байгаа юм. Нэр томьёо тодорхойлогдсон байгаад байгаа юм тэндээсээ. Болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг ашиглан гээд. Бас аппликейшн түвшинд энийг бас ашиглах ийм бололцоотой байгаа.

Тэгээд энэ цаанаа бүтээгдэж байгаа нь бол программчлал юм гэдэг ийм нэр томьёоны тодорхойлолтоор оруулж өгсөн байгаа юм. Баасанхүү гишүүний бас тодотгож асууж байгаа нь энэтэй холбоотой зохицуулалтаа хийж чадах юм уу гэж асуусан. Энийг бол хуулийн төслийн 48.9 дээр бол цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн байгууллага зохицуулах хороо хамтраад сонгуулийн төв байгууллагаараа батлуулахаар бол хуулийн төсөлд бол тусгаад явж байгаа.

С.Бямбацогт: 2 дугаар асуултад ажлын хэсэг. Тогтохсүрэн гишүүний микрофон өгье.

Д.Тогтохсүрэн: Баасанхүү гишүүний асуултад хариулъя. Энэ 3.1.9 бол ял эдэлж байгаа гэдгээ тодорхойлж нэр томьёоны хувьд нь тодорхой болгож өгсөн ийм заалт байгаа. Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг бол хууль санаачлагчаас бол орж ирээгүй юм байна лээ. Одоо мөрдөж байгаа манай Төрийн албаны хуульд бол авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон хүн бол шүүхээр шийдэгдсэн хүн бол дахиж төрийн албанд орохыг хориглож байгаа. Энэ зарчмыг бол цаашдаа барих ёстой гэж бодож байгаа.

Энэ асуудлаар бол би дараа нь санал хураагаад явах үед бол Баасанхүү гишүүн бодвол зарчмын зөрүүтэй саналаа гаргаад хураалгаад явах эрх бол танд бол нээлттэй байж байгаа.

С.Бямбацогт: Дараагийн санал. Дараа нь бас гарах байх асуудлууд тийм ээ. 9. Одоо санал хураалт явуулна тийм ээ? 8 дугаар саналаар санал хураалт

явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжлээ.

9 дүгээр санал. 9.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас” гэснийг “аймгийн төв болон дүүрэгт 3000- аас дээшгүй” гэж өөрчлөх, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

10 дугаар санал. 10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “талаар” гэсний ард “байр сууриа илэрхийлэх,” гэж нэмэх, санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 11 дүгээр санал.

11.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хороог” гэсний дараа “тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “өмнө” гэсний дараа “тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн энэ саналыг дэмжлээ. 12 дугаар санал.

12.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн энэ саналыг дэмжлээ. 13 дугаар санал.

13.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.16 дахь хэсгийн “журмыг” гэснийг “, сонгогч шилжих журам болон маягт, загварыг” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн энэ саналыг дэмжлээ.

14.Төслийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “энэ хуулийн 23.2-т заасны дагуу цахим хуудаст байрлуулсан” гэснийг хасах, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Батзандан гишүүн асуулт асууя. Санал хураалтыг цуцалъя.

О.Батзандан: Олон мандаттай томсгосон тойргоор сонгууль явуулах тухай хуулийн төслийг эрх баригч нам оруулж ирж байна. Яг энэ хуулийн төслөөр 2008 онд сонгууль явуулж, 7 сарын 01 болж байсан юм. 7 сарын 01-нийхээ алдаанаас суралцаж чадсан уу гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байгаа юм. Яагаад 7 сарын 01 болсон юм бэ гэдгийг. Ажлын хэсгийн ахлагчаас бас тодруулахыг хүсэж байна. Яагаад 7 сарын 01 болсон юм бэ? Баянгол дээр учиртай 3 толгой, Сонгино дээр учиртай 4 толгой, Баянзүрх дээр учиртай 2 толгой ургасан учраас 7 сарын 01 болсон юм.

Сонгуулийн луйвар хэрээс хэтэрсэн учраас 7 сарын 01 болсон юм. Нам дотроо фракц бүлгээрээ хэмлэлдэн талцсан учраас 7 сарын 01 болсон юм. Өөрөөр хэлбэл Сонгуулийн хуулийн процесс, процедурыг зүйл заалтууд сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх механизм тодорхойгүй байсан учраас. Сонгуулийн үеэр гардаг маргаан зөрчилдөөнийг зохицуулах зохицуулалт тодорхойгүй байсан учраас 7 сарын 01 болсон юм. Энэ хууль чинь сонгогчдын

болон нэр дэвшигчийн намуудын сахилга батыг алдагдуулж, 7 сарын 01 рүү хөтөлдөг хууль шүү.

92, 93 оны тухай ярьж байна. Тэр үед бол Монголын нөхцөл байдал өөр байсан. 7 сарын 01 рүү хөтлөхгүй гэдэг баталгаагаа эрх баригч нам гаргаж өгөөрэй. Энэ дээрээ онцгой анхаараарай гэдгийг би та бүхэнд хэлэхийг хүсэж байна. Их л яаруу сандруу явж байна шүү. Томсгосон 26, 50 гэдэг хувилбараасаа 3 хоногийн өмнө татгалзаад өнөөдөр шуруулж байна. Бушуу туулай борвиндоо баастай гэдэг үг бий. Их бодсон биз гэж би ажлын хэсгийн даргаас асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Тогтохсүрэн гишүүн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Батзандан гишүүний асуултад хариулъя. 2008 оны 7 сарын 01-нтэй холбогдуулж асууж байх шиг байна. Би бол 2008 оны 7 сарын 01 бол энэ томсгосон олон мандаттай томсгосон тойрог буюу системдээ учир дутагдалтай учраас 7 сарын 01 болсон гэж бодохгүй байгаа юм. Энд хэд хэдэн зүйл байгаа шалтгаан нь. 1 дүгээрт сонгууль юу санал хураалтын дүнг гараар тоолсонтой холбоотой маргаанууд их үүссэн байдаг юм байна лээ.

Одоо бид 2012 оноос хойш энэ сонгуулийн автоматжуулсан төхөөрөмжийг ашиглаад сурсан. Энд ямар нэгэн алдаа мадаг гарахгүй байгаад байгаа юм. Тийм учраас бол сонгуулийн автоматжуулсан системээр явах учраас энэ зөрчил арилсан болов уу гэж арилсан гэж ингэж бодож байна.

2 дугаарт Сонгуулийн хуулийн хариуцлага их тодорхой болсон. Сонгуулийн хуультай хамт Зөрчлийн хууль орж ирсэн. Энэ Зөрчлийн хуулиар Сонгуулийн зөрчсөн тохиолдол бүр дээр хариуцлага нь өөр, өөр байгаа. Нэг хэсэг нь нэр татахаар байгаа, нэг хэсэг нь албадлагын арга хэмжээ авахаар байгаа. Нэг хэсэг нь торгуулийн арга хэмжээ авахаар байгаа. Тийм учраас бол хариуцлага маш их тодорхой. Хэн авах вэ, яаж авах вэ гэдэг нь бүгд тодорхой байгаа. Тийм учраас би хариуцлагыг их тодорхой болсон гэж ингэж бодож байгаа юм.

Монгол ардын нам буюу эрх баригч нам яагаад өөрчилсөн бэ гэдэг асуудал ярьж байна сонгуулийнхаа системийг. Хууль санаачлагч 50, 26 гэдэг сонгуулийн системийг өргөн барьсан. Энийг бол 26 нь бол одоо мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж магадгүй юм. Нэр дэшилт буюу санал өгөлт нь бол мажоритар системээр яваад байгаа мөртөө санал тоолох, хувь тэнцүүлэх хэлбэр рүү ороод байна. Тийм учраас Үндсэн хууль зөрчсөн юм руу орчих вий 1 дүгээр асуудал нь.

2 дугаарт нь сонгогчдын зүгээс нөгөө л намын нэрийн ард нуугддаг юм гарах вий гэдэг ийм болгоомжлол байсан учраас 50, 26 гэдэг өргөн барьсан системийг өөрчилж одоо улс орныхоо эдийн засагт бас эерэг нөлөөлөл бий болгодог асуудлыг арай улс орныхоо хэмжээнд авч үздэг ийм том тойрогтой байх нь зүйтэй юм гэж үзэж энэ олон мандаттай томсгосон тойрог гэдэг системийг авахаар шийдвэрлэсэн юм.

С.Бямбацогт: Тодруулах боломжгүй. Хэлэлцэж байгаа яг санал дээрээ саналаа хэлээрэй та. Дараа нь асуугаарай. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт. 15 дугаар санал.

15.Төслийн 26 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26, 27 дугаар зүйл болгох:

“26 дугаар зүйл.Сонгогч шилжих

26.1.Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

26.2.Нэр дэвшигч болон энэ хуулийн 38.3-т заасан менежер, шадар туслагч сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.

27 дугаар зүйл.Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох

27.1.Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

27.3.Энэ хуульд заасан нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 27.1, 27.2-т заасан иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуустал үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.4.Ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулахаар товлон зарласан эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” 27.2 дээр бас засаад уншъя. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана гэж засъя.

Ингээд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Эрдэнэбат гишүүн саналаа хэлье.

Д.Эрдэнэбат: Энэ 27.3 дээр найруулгаа харахгүй бол хар даа ингэж байна шүү дээ. Энэ хуульд заасан нэмэлт болон дахин санал хураалт гэхээр энэ нэмэлт болон дахин санал хураалт гэдэг чинь зүйл заалтаар энэ хуульдаа хамрагдаад явж байгаа шүү. Тэгээд дахиад энэ хуулийн 27.2 гээд наадах чинь найруулгын

хувьд нэг тийм утгагүй зүйл болсон. Тэрийгээ янзлаарай. 27.3 дээр чинь тийм юм биччихэж.

С.Бямбацогт: Ажлын хэсэг найруулга дээрээ анхааръя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. 16. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “дараах” гэсний дараа “асуудлыг олонхоороо шийдвэрлэх бөгөөд” гэснийг нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Үндсэн хуульд орсон. 12 гишүүн санал хураалтад оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.3, 30.4.4 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.2.6, 33.3.6 дахь заалтыг хасах, санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

19.Төслийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.7.Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор. Батзандан гишүүн.

Ж.Батзандан: ШИНЭ намын зүгээс тодорхой санал гаргасан. Нэр дэвшигчийг тодорхой төрлийн нэр дэвшигчийг хязгаарлах тухай. Тухайлбал бага насны хүүхэд хүчиндэж байсан, охид хүүхнүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж байсан, авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдээд шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор шийтгэгдэж байсан. Хүн амины хэргээр шоронд ял эдэлж байсан хүмүүсийг Улсын Их Хуралд нэр дэвших эрхийг нь хязгаарлах нь зүйтэй гэж ШИНЭ нам үзэж байгаа юм.

Эх орноосоо урвах тагнуул хийх гэх мэт зүйл ангиудаар шийтгэгдэж ял эдэлж байсан хүмүүсийг Улсын Их Хуралд болон бүх шатны сонгуульд нэр дэвших эрхийг нь хязгаарлах нь зүйтэй гэж ШИНЭ нам санал гаргаж байгаа. Парламентын суудалтай намууд ч гэсэн ийм санал, парламентын бус суудалгүй намууд ч гэсэн ийм саналыг гаргаж байгаа. Энийг зарчмын зөрүүтэй санал болгож хураалгахыг хүсэж байна.

С.Бямбацогт: Д.Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Энд нэг ийм салаа ойлголт яваад байна л даа. Түрүүн ажлын хэсэг дээр энэ дээр тайлбар хийсэн шүү дээ тийм ээ. Нөгөө олон нийт намуудтай уулзахад хүний сонгох эрхэд нөлөөлөөд байна гэсэн учраас ажлын нөгөө өргөн барьсан хуульд оруулж ирээгүй байна гэж би ойлгосон тийм үү энэ асуудлаар. Тэгээд одоо энэ дээр хэрэв энэ гадна байгаа улс төрийн намууд төрийн бус байгууллагууд ингэж болохгүй, энийг нь хориглох ёстой гээд одоо ялгаагүй шүү дээ. Ял эдэлж байсан л гэсэн үг байхгүй юу даа тэр чинь тийм биз дээ.

Хүн алсан уу, хүүхэд хүчирхийлсэн үү, авлига авсан уу, албан тушаал тийм ээ тушаалаа урвуулан ашиглаад ял эдэлж байсан ийм улсууд болохгүй л гэвэл бүгдээрээ болохгүй. Бүгдээрээ л болохгүй. Тийм учраас одоо энэ дээр ямарваа нэгэн популист хандлага энэ хуульд бол хэрэггүй. Үнэхээр хэрэггүй. Тэгвэл одоо бүгдээрээ зарчмаа зөрүүтэй саналаа гаргадаггүй уу, ажлын хэсэг нь дахиад яриад шийддэг үү тийм ээ, ял эдэлж байсан урд нь, өмнө нь ял эдэлж байсан ямар ч юмаар хамаагүй. Энэ улсууд Их Хурлын сонгуульд нэр дэвших эрхгүй гээд л хийчихье л дээ. Тэгэхгүй бол одоо бусад намууд нь нэг их цэвэр үлдээд ч байгаа юм шиг.

Өөрсдийнхөө улсуудыг хамгаалаад ч байгаа юм шиг, ийм хөгийн байдалд бид нар орж болохгүй шүү дээ. Энэ чинь Их Хурлын сонгууль. Би ойлгохдоо энийг ярилцах нөхцөл юу үүссэн бэ гэхээр тэр олон нийтийн хэлэлцүүлэг Сонгуулийн хуулийн үеэр хийж байхад ийм санал одоо бусад газруудаас хүний эрхэд халдсан асуудал байж болохгүй шүү гэдэг ийм санал олон гарсан учраас энийг оруулж ирээгүй л гэж би ойлгоод явж байсан чинь өнөөдөр одоо юу ч болоод байгаа юм.

Нэг хэсэг нь хамгаалаад ч байгаа юм шиг, надад хамгаалах ямар нэг юм уу, Ардчилсан намд хамгаалах ямар ч шалтгаан байхгүй шүү. Үнэхээр тийм гэвэл ярилцаад л асуудлаа шийд. Болж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн саналаар санал хурааж байгаа. Ажлын хэсгийн санал хурааж дууссаны дараа зарчмын зөрүүтэй саналууд гишүүд гаргах эрх нь нээлттэй байгаа. Саяын одоо байр сууриуд дээр тодорхой хариултуудыг ажлын хэсэг болон дэд ажлын хэсгээс хариулт өгсөн.

19 дүгээр санал хураалт явуулъя. Төслийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.7.Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 20 дугаар санал.

20.Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “маягтад” гэсний дараа “тухайн сонгуулийн тойргийн” гэж нэмэх, тухайн сонгууль гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тухайн тойргийн сонгуулийн гэж нэмэх, санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг “ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би ийм зүйл хэлэх гэсэн юм. Одоо энэ Эрүүгийн хуулийн шинэчилсэн тэр онцлог байгаа шүү дээ. Бид нар одоо 2015 оноос шинэ хуулиар явж байгаа. Тэгэхээр манай хууль дээр ямар байдаг вэ гэх юм бол, энэ одоо ял шийтгэлтэй хугацаа гэж ойлголт байхгүй. Тэгээд ял шийтгэлтэй байгаа бол мэдээж тэр чинь гэмт хэрэгтэн гэдэг нь тодорхой учраас гэмт хэрэгтэн гэсэн үг шүү дээ.

Шоронд байна уу, одоо тэр нь одоо юу байдаг юм тодорхой зөрчих эрхийг хязгаарласан байна уу, торгуулийн байна уу. Торгуулийн чинь торгуулиа төлөөд л болоо биз дээ. Тэнсэнтэй бол тэнсэнгийн хугацаа нь дуусаад л тэгээд л болоо шүү дээ.

Тэгэхээр ийм нэг ял шийтгэлтэй гэсэн бичгийг хүн бүр очиж авах юм уу, яах юм бэ гэдэг асуудал гараад байгаа байхгүй юу хэлбэрийн маягаар. 2 дугаар нь цагдаагийн байгууллага дээр тодорхой цагдаагийн байгууллага дээр энэ хэрэг нь энэ хүн цагдаагийн байгууллагын нэг бичиг авах юм байна гэж би ойлгож байна. Харин миний хэлээд байгаа түрүүний санаа бол хүн одоо ял эдэлж байна уу, ял эдлээгүй юу, ямар л эдэлсэн бэ гэхээсээ илүү энэ төрд гай болох хүн үү, гай болох биш хүн үү гэдэг нь чухал шүү дээ.

Шулуухан хэлэхэд. Хүн өнөөдөр бага залуудаа өнөөдөр юу гэдэг юм санамсар болгоомжгүйгээр хэрэг хийсэн байж болно. Дараа нь одоо юу гэдэг юм өөр сайхан амьдарч байгаа хорвоо дэлхий дээр байгаа олон янзын жишээ байна. Ялангуяа гаднын оронд бол бага залуудаа хүмүүжил тааруухан байсан нөхөд чинь хууль хүчний байгууллага, хүчтэй сайн ажилладаг гээд авах сонирхол байдаг. Тэгэхээр өнөөдөр юу вэ гэх юм бол энэ албан тушаалын хэрэг гэдэг чинь шал өөр байхгүй юу. Тэгэхээр албан тушаалын хэрэгт шалгагдаж байгаа албан тушаалын хэргээр одоо эрүүгийн хэргээр сэжигтэн яллагчаар орсон хүмүүсийг оруулахгүй байя гэдэг ийм заалтыг оруулж болдоггүй юм уу? Энэ л чухал байна шүү дээ гол нь. Хүнд гай болоогүй яах вэ болгоомжгүйгээр санамсаргүйгээр.

Жишээ нь гэр бүлийн хэрүүлээс болоод нэгнийхээ очоод нүд амыг нь цохичихдог яг нарийндаа авах юм бол тэр нөхрийн буруу л байдаг шүү дээ. Эмэгтэйчүүдийг жишээлбэл. Тэгээд яадаг юм бэ дараа нь тэр хүн сайн сайхан яваад байгааг алийг тэр гэх юм бэ? Тэгэхээр хамгийн их санаа зовоож байгаа асуудал болохоор албан тушаал. Мэдсээр байж төрийг ашиглаж баяжих гэж байгаа хүмүүсийг л оруулмааргүй байна.

С.Бямбацогт: 21 дүгээр саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 7 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “600” гэснийг “200” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг доор дурдсанаар нэмэх:

“40.2.8.Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “хоёроос” гэснийг “дөрвөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.3.Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 7 гишүүн энэ саналыг дэмжлээ. Баасанхүү гишүүн дэмжлээ. Дэмжигдлээ.

26.Төслийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг “Энэ хуулийн 42.3-т заасны дагуу тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар болон ухуулах хуудас байршуулахыг хориглоно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42.5 шүү. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “Ухуулах” гэснийг “Нэр дэвшигч нь ухуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 42.14 дэх хэсгийг доор дурдсанаар нэмэх:

“42.14.Энэ хуулийн 40.2.8-д заасан сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

29.Төслийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.8, 43.9 дэх хэсгийн “самбарыг” гэснийг “самбар, дэлгэцийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 11 гишүүнээс 10 гишүүн энэ саналыг дэмжлээ.

30.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “ухуулах байр,” гэсний дараа “сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 11 гишүүнээс 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт, арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Төслийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.8.Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийн 47.9.2 дахь заалтын “сүүлийн зургаан сарын” гэснийг “ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ганцхан үг шүү. Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би ингэж бодоод байгаа байхгүй юу. Дундаж гэхээр чинь нийлээд тэрнийх нь дунд талаар нь авна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр одоо жишээлбэл 100 мянга гээд үзэх юм бол 12 сараар бодох юм бол 1,2 сая, дундаж гэхээр 600 мянга. Тантай 600-аар гэрээ хийнэ гээд л тавьчихна. Тэгэхээр чинь энэ чинь өөрөө юу вэ гэх юм бол та нарын хэлээд байгаа санаа бол юу вэ гэх юм бол сүүлийн 6 сард байсан нь сарынхаа аль нэг сарынхыг нь аваад, тэрүүгээрээ үнээ тогтоо л гэсэн санаа хэлээд байна гэж би ойлгосон шүү дээ. Гэтэл наана чинь дунджаар гэдэг үг чинь тийм байдал үүсгээд байна.

С.Бямбацогт: Нямаа Энхболд гишүүн. Эрдэнэбат гишүүн тодруулъя. Дараа нь Энхболд гишүүн хариулъя.

Д.Эрдэнэбат: Энэ Баасанхүү түрүүн нэг халт гараад төөрөөд явчих юм. Энэ сурталчилгааны нэвтрүүлэг хийнэ гэдэг бол телевизийн төлбөр тийм ээ, би тэгж ойлгож байгаа. Одоо цахим сайтууд байгаа. Яг завсардаад байгаа байхгүй юу наадах чинь. Тэгэхээр энэ дээр сурталчилгаа, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг болон цахим сайтуудын төлбөр нь гэдэг юмыг оруулахгүй бол наад дунд чинь цахим сайтын цоорхой гараад ирж байгаа. Бүгд ижил байх хэрэгтэй наад дээр чинь. Авбал бүгдээс нь ав, авахгүй бол бүгдээс нь жижиг, дунд тогтоо.

Тэгэхээр би энэ цахим гэдэг тийм ээ, одоо цахим үйлчилгээ гэдэг юм уу, юу гэдэг юм. Нэг зөв томъёоллыг нь ороод нэмээд хийе гэсэн ийм саналтай байна.

С.Бямбацогт: Энхболд гишүүн.

Н.Энхболд: Ерөнхийдөө Баасанхүү гишүүнээ нөгөө энэ дундаж гэдэг чинь цагийн минутын тэд, секундйн тэд энэ тэр гээд хэрэглээд явчихдаг шүү дээ. Тийм нэвтрүүлэгт тийм. Тэр дунджуудыг нь ярина уу гэхээс түүнээс 6 сар тэд авсан байсан, тэрний дундаж гэхгүй. Яг нөгөө тариф маягийн юм тогтоосон байдаг шүү дээ нэвтрүүлгийн. Тэд нарынхаа л түрүү жил биш, биш. Тийм. Түрүү жилд мөрдөж байсан дундаж гэдгээр нь оруулах юм байна лээ. Би харин сая Эрдэнэбат гишүүний санал бас орох ёстой юм байна гэж бодож байна. Яагаад гэвэл цахим сайтууд чинь бас төлбөртэй юм явуулаад эхэлбэл бас хамаа намаагүй нэмээд байж магадгүй л юм байгаа юм.

С.Бямбацогт: Тэгэхээр Лувсан-Очир бас 1 дүгээр микрофон би яг хэлье. Энд сурталчилгааны тийм үү нэвтрүүлгийн төлбөр гэж байгаа тийм ээ. Энэ нь жилийн хугацаанд баримталсан төлбөрийн дундаж хэмжээнээс тийм үү хэтрэхгүй гэж байгаа юм. Энд чинь тэгэхээр рекламных юм уу, эсхүл нэвтрүүлгийнх юм уу? Телевиз чинь бол реклам чинь бол 1 секундээр тооцогдоод явчихдаг. Хэрэв

нэвтрүүлэг бол минутаар тийм үү, тэгээд дээрээс нь цагаар тооцогдоод явчихдаг. Сайт дээр чинь бас реклам өөр төлбөртэй, нийтлэл мэдээ өөр төлбөртэй. Энийг бид ялгаж бичихгүй бол дараа нь ингээд их ойлгомжгүй орж байна шүү дээ бас. Одоо хариулаад байх тэр бололцоотой юу, бололцоогүй юу? 1 дүгээр микрофон.

А.Лувсан-Очир: Харилцаа холбооны зохицуулах хороо Лувсан-Очир.

А.Лувсан-Очир: Хуулийн төслийн 47.9.2-т болохоор сүүлийн 6 сар гэснийг сая сонгуулийн сурталчилгааны сонгуулийн жил эхлэхийн 1 дүгээр сарын 01-нээс өмнө 1 дүгээр сарын 01 гээд хугацааг нь өөрчилсөн. Энэ дээр хугацаанд хийж байгаа 3-аас доошгүй зар сурталчилгааны нэвтрүүлгийн гэрээ, тэр гэрээн дээр дурдагдсан үнэ тарифын 3-аас доошгүй гэрээний үнэ тарифын дунджаар тогтооно гэж 47.9.2 дээр заасан байгаа юм. Радио, телевизийн хувьд.

Радио, телевизийн энэ томьёолол дээр цахимыг бол оруулах бололцоогүй. Цахимыг оруулж ирвэл тусад нь оруулж ирэхдээ 48 дугаар зүйл дээр тухайлаад нэг зүйл, хэсгээр оруулж ирэх хэрэгтэй. Цахим дээр бол хоног гэж хугацаа хамаарна. Дээрээс нь баннерын нөгөө хэмжээ хамаарна. Тийм учраас хэмжигдэхүйц нэгжүүд нь өөр учраас энэ зүйлтэй давхцаж болохгүй. Тусад нь шинэ томьёоллоор оруулж ирж болно.

С.Бямбацогт: Тэр зар сурталчилгааных гэдэг чинь үндсэндээ бол реклам гэж ойлгогдох байна шүү дээ тийм үү?

А.Лувсан-Очир: Тийм зар сурталчилгааны нэвтрүүлэх гэрээ.

С.Бямбацогт: Нэвтрүүлэг гэдэг чинь өөр.

А.Лувсан-Очир: Тийм нэвтрүүлэх. Зар сурталчилгааны нэвтрүүлэх гэрээ секундээр хэмжигдэнэ гэсэн үг.

С.Бямбацогт: Харин тэгэхээр зар сурталчилгааных гэдэг чинь бол секундээр хэмжигдээд явах нь. Хамгийн өндөр тарифтай байдаг шүү дээ тийм ээ. Тэрүүгээр тооцогдож явах нь байна шүү дээ тийм ээ?

А.Лувсан-Очир: Тийм. Тэрний 3-аас доошгүй зар сурталчилгааны нэвтрүүлэх, зар сурталчилгаа нэвтрүүлэх гэрээг ирүүлнэ. Тэр 3-аас доошгүй гэрээний үнийн дунджийг гаргаж ирж 1 секундийг нь тодорхойлно гэсэн байгаа.

С.Бямбацогт: Саяын Эрдэнэбат гишүүний гаргасан саналыг тэгээд тэр цахим сайтууд тийм ээ бас оруулахыг ажлын хэсэг оруулах, ер нь оруулсан томьёоллоор уншаад явчихъя л даа тийм. Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь гэдгийн ард талд нь тийм ээ цахим сайтуудын бас төлбөр нь гэдэг агуулгаар дэмжээд санал хурааа. Санал хураалт саяын агуулгаар дэмжээд, цахим сайтуудыг оруулна гэсэн агуулгаар дэмжээд санал хураалт. Одоо хураавал яасан юм бэ тийм ээ? Саяын тэр цахим сайт, санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Ажлын хэсэг энэ дээр нэг саналын томьёолол бэлдээд бид нар сүүлд нь хураачихъя. Саяын цахим сайтуудыг бас хамруулах тийм үү, жилийн хугацаанд. Тусад нь зүйл, заалт болгоод. Тусад нь заалт болгоод.

33.Төслийн 47 дугаар зүйлийн 25 дахь хэсгийн “47.2, 47.5-47.8, 47.11-47.19-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 34. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Төслийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.7.Энэ хуулийн 36.3, 48.4-т заасны зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна:” санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

35.Төслийн 48 дугаар зүйлийн 48.8 дахь хэсгийн “Интернэтийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсгийн “хороо” гэснийг “хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 11 гишүүн оролцож, 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

37 дугаар санал. 37.Төслийн 48 дугаар зүйлд “Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.” Гэсэн 11 дэх хэсэг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжлээ.

39.Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “нь” гэснийг “тус бүр” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар санал дэмжигдлээ. 40 дүгээр санал.

40.Төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “гурван сая” гэснийг “таван сая” гэж, “арван таван сая” гэснийг “хорин сая” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Талдаа орж байна. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн энэ саналыг дэмжлээ.

41.Төслийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“55.2.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 55.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хандив өгч болно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

42.Төслийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 12 гишүүнээс 10 гишүүн энэ саналыг дэмжлээ.

43.Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.” Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би нэг энэ нэг ийм төрийн аудитын дээд байгууллага зардлын тайлан гээд. Энэ нөгөө мөрийн хөтөлбөр өгөхдөө аудитаар ордог хэвээрээ юу. Тэгээд аудит чинь одоо жишээлбэл яаж ирээдүйд гарах төсвийг үнэлж аудит хийгээд байгаа юм бэ? Манайх чинь одоо үнэгүй байр, үнэгүй янз бүрийн юм өгье гээд тэгээд өрийг нь тэглэе гээд ярьсан байгаа шүү дээ. Ардчилсан нам чинь нөгөө бүх хүний өрийг тэглэнэ гээд ярьсан байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ аудитын энэ нэг хэлбэрийн төдий аудит ордог юм уу яг жинхэнээсээ ингээд яг гарсан зүйлийн тооцооллыг нь гаргаад тоог нь гаргаад нээрээ энэ үнэхээр одоо бололцоотой юм байна гэдэг одоо хөтөлбөр байна гэж гаргадаг юм уу? Аудитаар батлуулчихсан бол бид тэрийг ярьж болно. Батлаагүй бол тэрийг ярих боломжгүй шүү дээ. Одоо хүн болгон л мэдээж, нам болгон л гоё, гоё юм ярина. Жишээлбэл манай Ардын намынхан чинь хүүхэд болгоныг сургуультай, цэцэрлэгтэй одоо хүү багасгана гээд л аудитаар болно гээд тэгсэн. Одоо болоогүй шүү дээ. Тэгэхээр энэ аудитын энэ дүгнэлт ямар ач холбогдолтой юм бэ? Мөрийн хөтөлбөрийн санхүү дээр нь хяналт тавиад байгаа юм уу? Эсхүл бололцоотой, бололцоогүй гээд хяналт тавиад байгаа юм уу?

С.Бямбацогт: Энхболд гишүүн. Дараа нь аудитынхан бас бэлдэж байгаарай нэмэлт.

Н.Энхболд: Нөгөө энэ чинь тэр нөгөө сонгуульд орох үеэр аудитаар хянуулах чинь төрийн хууль тогтоомжтой нийцэж байна уу, нөгөө Төсвийн тухай хууль, төсөвт тавьдаг тусгай шалгууруудын тухай хуультай, тэгээд ерөнхийдөө улсын эдийн засаг, санхүүгийн хүчин чадалтай нийцэх нь үү, үгүй юу, янз бүрийн хамгийн наад зах нь гэхэд нөгөө урт хугацаа, дунд хугацааны хөтөлбөрт нийцсэнээс илүү янз бүрийн амлалт авсан байх юм бол жишээ нь бүх юмыг улс 100 хувь болгоод бүгдийг нь мөнгийг нь тарааж өгнө ч гэдэг юм уу? Гэх мэт тийм юм заалтууд талаас нь аудит хянаж байгаа. Энэ бол зөвхөн зүгээр нөгөө сонгуульд оролцож байгаа хүний байгууллагын зардалтай холбоотой 2 өөр заалт байгаа шүү Баасанхүү гишүүнээ. Нөгөөх нь бол өөр. Энэ дараах тухай юм тийм.

С.Бямбацогт: Тэр хэн Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Энхбаатар. Нэмээд хариулаарай Энхбаатараа бас. Тэгээд бид нар чинь мөрийн хөтөлбөр бас Монгол Улсын төсөв, санхүү, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх ёстой. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх ёстой шүү дээ.

Тэгэхгүй үнэгүй байр олгоно, үнэгүй машин өгнө, үнэгүй эмнэлэг, үнэгүй сургууль гээд амлачихдаг. Тэрийг нь одоо хянаад яах ёстой юм бэ? Энэ дээр тодорхой ямар зохицуулалтууд байгаа билээ? Тэрийгээ маш тодорхой хариулаад өгчихөөрөө бас нэмээд.

Н.Энхболд: Энэ худлаа боломжгүй гэдгийг нь зарлах ёстой биз дээ аудитын байгууллагаас тийм.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон.

С.Энхбаатар: Үндэсний аудитын газрын Энхбаатар. Сая Энхболд гишүүн тодорхой хариулчихлаа. Үндэсний аудитын газар сонгуульд оролцох нам, эвсэл нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хянаж дүгнэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зохицуулалттай. Энэ бол бид Төрийн аудитын тухай, Сонгуулийн тухай хуульд зааснаар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхэд нь дүгнэлт гаргаад хэрэв нийцэхгүй байх юм бол тухайн нам, эвсэлд нийцэхгүй байгаа хэсэг дээр нь дүгнэлт хүргүүлээд тухайн одоо нийцэхгүй байгаа хэсэг нь залруулаад ингээд эцсийн байдлаар дүгнэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлдэг.

Одоо энэ саяын яригдаж байгаа зохицуулалт бол сонгууль зохион байгуулсны дараа тухайн нам, эвсэл нэр дэвшигчээс сонгуульд зарцуулсан зардлын тайланг нь хүлээн аваад, хянаад ингээд олон нийтэд мэдээлдэг ийм зохицуулалт байгаа.

С.Бямбацогт: Тодорхой хариулчих л даа тэр үнэгүй машин, үнэгүй байр, 10 сая төгрөгийн цалин, 2 сая төгрөгийн тэтгэвэр энийг хянаад үнэхээр одоо Монголын эдийн засаг, санхүүгийн чадавх даахгүй, урд дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцэхгүй ийм одоо бүтэхгүй зүйлийг амлаж байгаад аудитыг хянаад яг ямар дүгнэлт гаргаж, ямар хуулийн заалтын дагуу яг яах, ямар арга хэмжээ авах юм бэ? 4 дүгээр микрофон.

С.Энхбаатар: Мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн үзэл баримтлалд нийцээгүй бол нийцээгүй байна гэсэн дүгнэлтийг буцаагаад тухайн нам эвсэл нэр дэвшигчид нь буцааж хүргүүлээд, хэрэв дурдсан хугацаанд ирүүлээгүй бол бид дүгнэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэхгүй гэсэн үг. Хэрэв нийцүүлээд ирүүлэх юм бол нийцсэн дүгнэлтийг нь Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлдэг ийм зохицуулалттай байгаа.

С.Бямбацогт: Нийцээгүй сонгууль юу, нийцээгүй дүгнэлтээ бол сонгуульд оролцохгүй мөрийн хөтөлбөргүй учраас сонгуульд оролцохгүй тийм үү?

С.Энхбаатар: Тийм.

С.Бямбацогт: Тодорхой юм байна. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

44.Төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 дахь хэсгийн “22.00” гэснийг “21.00” гэж өөрчлөх. Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Гишүүдээ энийг нэг анхаарахгүй бол болохгүй. Энэ нөгөө сонгууль дуусах хугацааны асуудал. Ажлын хэсэг бол зөв томьёолол оруулж ирсэн юм. 22 цагт дуусна гээд. 22 цагт дуусах томьёоллоо бол би зөв томьёолж орсон. Сая ажлын хэсэг дээр энийг санал хураагаад 21 болгосныг нь би буруу гэж хараад байгаа юм. Яагаад вэ гэхээр сонгуулийн тойрог томсох тусам ирц хойрго болдог байхгүй юу. Иргэдийн ирц. Одоо бид нар 50+1 гээд босго ингээд тавьсан шүү дээ. Нөхөн сонгууль явна хүрэхгүй бол гээд хийчихээр. Энийгээ гүйцээхгүй сонгуульд дуусах магадлал бол олон тойрог дээр гарах гээд байгаа юм.

Тийм учраас ганцхан цагийн зөрүү 22 цагаар дуусгах нь бол аягүй зөвөө. Нэг 4 жилд нэг удаа явуулж байгаа сонгуулийг бид нар цагийн ганц цагийн зөрүү дээрээс ингээд ирц нь хүрэхгүй нэг баахан дутуу л сонгууль болох вий гэж би болгоомжлоод байгаа юм. Тэгээд найдвартай нь хийсэн нь дээр гээд ингээд байхад ажлын хэсэг дээр одоо энийг унагаагаад 21 цаг гэж босгодгийг буруу гэж хараад байгаа байхгүй юу. Амьдрал баян шүү дээ. Одоо бол жижиг тойрог байсан бол өөр. Жижиг тойрог дээр бол одоо илүү сонгогчдтойгоо ойрхон байдаг учраас тийм ээ санал өгүүлэх тал дээр хүн болгон ингээд санаачилгатай ажилладаг байхгүй юу тийм.

Удахгүй хурдан гарна. Одоо наадах чинь олон намууд томсгосон тойрог гээд нэр дэвшигч нь олон мандаттай олон нэр гараад ирэхээр саатал бол цагийн хугацаа бол маш их орно. 2 дугаарт тойрогтоо ингээд хүрч ажиллах боломж нь нэр дэвшигч илүү багасаж байгаа байхгүй юу. Тийм учраас сонгогчдын идэвх муудах хандлага магадлал нь өндөр болно.

Би яг л нэг амьдрал дээр тохиолдсон зүйлийг яриад байна шүү дээ. Энэ бол нийт эрх ашиг, нийт сонгогчдын болон одоо нэр дэвшигчдийн эрх, ашгийн асуудал байхгүй юу даа. Тайван бололцоотой саналаа өгөх нөхцөл бололцоог бүрдүүлэх. Тийм учраас би та бүхнээс хүсэж байна. Энэ саналыг өөрчлөөд 22 цаг гэснээ хуучнаар нь үлдэхийг дэмжиж хэдүүлээ саналаа өгье гэж. Би зарчмын зөрүүтэй саналыг буцаагаад 22 цаг гэдгээр гаргаж байна. Өөрөөр хэлбэл энийг битгий дэмжээч. 21 гэж өөрчлөхийг битгий дэмжээч. Ажлын хэсгийн юу оруулж ирсэн хуучин саналаар нь энийг явъя гэсэн ийм санал оруулж байна.

С.Бямбацогт: Саналын томьёоллыг уншсан. 22 гэснийг 21 болгож өөрчилъе гэсэн саналыг, 5 ажлын хэсэг Содномцэрэн гуай 5 дугаар микрофон.

Ч.Содномцэрэн: Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс саналаа хүргүүлэхдээ энэ 22 цагийг хуучнаар нь хэвээр нь байлгах санал хүргүүлсэн. Ажлын хэсэг дээр санал хураагаад 21 цаг болгосон. Тэгэхээр хуучнаар нь байлгаж өгөөч ээ л гэж хүсэх байгаа 22 цаг. 2008 онд 20 цаг болгоод Их Хурал орон нутгийн сонгууль хамт явагдахад бол ялангуяа орон нутгийн сонгууль дээр бол бүх аймаг, бүх дүүргүүдэд бол ирц хүрээгүй, хэсгүүдэд бол нэмэлт санал хураалт явагдсан.

2016 онд Улсын Их Хурлын сонгуулиар Төв аймаг, Баянхонгор аймагт бол зарим хэсэг дээр ирц хүрэхгүй нь гэдэг ийм мэдээлэл манайд ирж байсан. Яах вэ 22 цаг одоо хаах дөхөж байна. Ирц хүрэхгүй нь гэсэн. Тэгэхээр зэрэг энийг бол бид бол нэг цагийн зөрүүгээр ингэж нааш татах бол шаардлагагүй. Хуучнаар нь байлгаж өгөөч гэсэн ийм хүсэлт гаргаж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ерөнхийдөө нөхцөл байдлаа ойлгосон тийм ээ. Тийм ээ бас дэмжихгүй байх нь зөв байх. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 2 гишүүний энэ санал дэмжигдсэнгүй. 22 цагаараа үлдлээ.

45.Төслийн 63 дугаар зүйлийн 63.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.13.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

46.Төслийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

47.Төслийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсгийн “Бие эрхтний согог, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдал,” гэснийг “Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон” гэж өөрчлөх, гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энийг санал хураалтыг дараа хийчих үү? 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 48 дугаар санал. Энхболд гишүүн. Энхболд гишүүний микрофон өгье.

Н.Энхболд: Сонгуулийн ерөнхий хорооныхноос асуух гээд байна. Сая 64.1.5-г бид хасчихлаа л даа. Тэгээд энэ дээр хилийн цэргийн гэдэг юмтай нь зөрчилдөх юм гараад. Тэгээд хилийн цэрийн жижиг застав дээр бол заавал хэсэг байгуулж байж хурааж байгаа юу? Тийш нь хайрцаг явуулж итгэмжлэгдсэн юугаар авч байгаа юу? Тэгэхээр тэр эндээс хасагдаж байгаа байхгүй юу. Өөрсдөө авчирч өгөх үү? Застав дээр саналаа хураачхаад авчирч өгөх үү? Хүмүүс ачиж ирээд. За, за. Тэрийг хэн Сонгуулийн хороо хариуцах уу, хил эзгүйрчихвэл хаана хариуцах вэ?

С.Бямбацогт: Болдсайхан дарга. 4 дүгээр микрофон.

Ц.Болдсайхан: Энхболд гишүүний асуултад хариулъя. Одоо мөрдөж байгаа хуульд бол хилийн цэргийн одоо заставуудад бол хүмүүсээ зөөж ирж тухайн хэсэг дээрээ санал өгүүлж байгаа.

Сая Засгийн газраас Сонгуулийн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өгсөн саналд бол тэр зөөврийн саналын хайрцгаар авахад энийг нэмж оруулж өгөөч оруулаач гэсний дагуу л оруулсан юм. Сая ажлын хэсэг дээр бол хуучнаар нь үлдээе гэж үзсэн л дээ.

С.Бямбацогт: 48.Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “гурав хүртэл” гэснийг “дөрөв хүртэл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

49.Төслийн 69 дүгээр зүйлийн 69.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“69.2.5.Сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

50.Төслийн 72 дугаар зүйлийн 72.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“72.11.Энэ хуулийн 72.5.3-т заасны дагуу саналын хуудсыг дахин тоолоход сонгогчдын саналыг тоолохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

51.Төслийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн “15 хоногийн” гэсний дараа “Улсын Их Хурал болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

52.Төслийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79.3.Энэ хуулийн 9.10-т заасны дагуу дахин сонгууль явуулахад улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээс ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулиар гаргаж хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

53.Төслийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн дараа доор дурдсан агуулга бүхий хэсэг нэмэх, үүнтэй холбоотойгоор 80.3 дахь хэсгийг “ирцийг” гэснийг “ирц, саналын тоог” гэж, “ирц” гэснийг “ирц, саналын тоо” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх хэсгийг “Нэмэлт санал хураалт гэж энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу явагдах санал хураалтыг;” гэж тус тус өөрчлөх:

“Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрт нэмэлт санал хураалт явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

54.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.5 дахь хэсгийн “81.5.” гэснийг “*Тайлбар*.” гэж, “их” гэснийг “илүү” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 7 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байгаарай санал хураалтууд явагдаж байгаа шүү. Дараагийн санал хураалт. 55 дахь санал.

55.Төслийн 48 дэх хэсгийн 48.5 дахь хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх.

“48.5.Энэ хуулийн 48.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энхболд гишүүн. Н.Энхболд гишүүний микрофон.

Н.Энхболд: Энэ тохиолдолд нөгөө сурталчилгааны нэвтрүүлэг гэдэг дээр адилхан тэр мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааны гэдэг үгийг нь хамт оруулж ирэх хэрэгтэй. Тэгэхгүй бол тэнд бас тодорхой биш үлдчихлээ. Зөвхөн одоо рекламныхан юутай. Та нар бол зөвхөн зар сурталчилгааныхаар гурвынхаар тооцно гэж ярьсан шүү дээ. Энэ дээр бол мэдээ, тэгэхээр энийг адилхан болгох хэрэгтэй байна. Урдах юман дээрээ бүр протоколд тусгаж өгөөд тийм ээ. Мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа зөвхөн зар сурталчилгаа биш шүү. Тэгэхгүй бол дангаар нь авчихвал аягүй өндөр болчихно. Тэгэхгүй болохоор мэдээ мэдээлэл гэж бичихгүй бол дангаараа үлдчих гээд байна. Адилхан болгох хэрэгтэй байна томьёоллыг нь.

С.Бямбацогт: Санал хураалт явуулъя. Дэмжигдсэн тохиолдолд бас бид нар протоколоор чиглэл өгье. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явъя. Хэд дэх заалт байсан билээ тэр чинь? Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулаад 48.3 дахь заалт билүү тэрэн дээр нөгөө зар сурталчилгааны нэвтрүүлэг гэсний ард зар сурталчилгаа, мэдээ мэдээллийн нэвтрүүлгийн гэсэн агуулгаар нэмж оруулах нь байна шүү. Энийг бас протоколд үлдээ. 47.9.2. Одоо юу? Тэгвэл саяын түрүүний томьёоллоо гаргаад ир дээ. Тэгье.

47.8 дээр шүү дээ тийм биз дээ. Телевизийг ярих гээд байна шүү дээ. 47.8 байгаа биз дээ энэ чинь. Тэгээд чи яагаад 48. Тийм. “Зар сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Сониныг бас адилхан. Тийм. Үүнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийн 47.9.2 дахь заалтыг сүүлийн сарын гэснийг 1 сарын 01-ний өдрөөс жилийн өмнө гэж өөрчилье гэж тоолсон шүү. Мэдээ, мэдээлэл. Санал хураалт. 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо адилхан орчихно бүгдээрээ. Сая хэлсэн. Дараагийн санал найруулгын санал уу, тийм ээ? Болсон уу?

Дараа нь. Найруулгаа дуусгачхаад. Ажлын хэсгийн саналаа эхэлж дуусчхаад. Найруулгын санал 2.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “заасны” гэсний дараа “дагуу” гэж, “хангасан” гэсний дараа “Монгол Улсын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын /цаашид “Улсын Их Хурлын” гэх/ сонгууль нь” гэснийг “Монгол Улсын Их Хурлын

сонгууль нь /цаашид “сонгууль” гэх/” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг “Монгол Улсын Их Хуралд /цаашид Улсын Их Хурал гэх/-д” гэж, мөн зүйлийн “4.4.1, 4.4.2, 4.4.3, 4.4.4” гэснийг “4.5, 4.6, 4.7, 4.8” гэж, мөн заалтуудын “сонгуулийг;” гэснийг “сонгуулийг ойлгоно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.2 дахь заалтын “26.6” гэснийг “26.3” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “24.1” гэснийг “24.2” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “21.1” гэснийг “25.1” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “21.5” гэснийг “25.5” гэж, 72 дугаар зүйлийн 72.1.2 дахь заалтын “78.5” гэснийг “72.5” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмж, хассантай холбогдуулан төслийн дугаар, эшлэлийг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав.Дагалдах хуулиудын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн дагалдах хуулиудын төсөл дээр гарч байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дээр санал хураалт явуулъя.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2.1 дэх заалтын “сонгуулийн тухай” гэсний дараа “болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дөрөв.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “8.3.8.Сонгууль” гэснийг “ээлжит бус, дахин, нөхөн сонгууль,” гэж өөрчлөх. Харин нэг жаахан давхар, давхар бичигдсэн байх шиг байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Тав.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 46.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.4.Төрийн жинхэнэ албан хаагч нь Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол

ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Зургаа.Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлээс “11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” гэж, мөн зүйлийн” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулга бүхий 3 дугаар зүйл нэмэх:

3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Долоо.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төсөлд "Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “заасан хэмжээгээр” гэсний дараа “шүүх,” гэж нэмэх.” Гэсэн агуулга бүхий заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1, 6, 11 дэх хэсгийн “учруулсан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 4 дэх хэсгийн “явуулсан” гэсний дараа нь “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 15, 16 дахь хэсгийн “оруулсан” гэсний дараа нь “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 23 дахь хэсгийн “тараасан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 31 дэх хэсгийн “устгасан” гэсний дараа нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 47 дахь хэсгийн “хийсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй.” гэж, 75 дахь хэсгийн “хэрэглэсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж, 30, 31, 32 дахь хэсгийн “бол” гэсний дараа “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлд заасан зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн харьцаанд нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдээ. Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулан

сая бол зарчмаар санал хураасан байгаа. Одоо маргааш чуулган руу орохдоо зүйл, заалт нэг бүрчлэн заалт нэг бүрээр нь энэ хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн харьцааг тодорхой болгож оруулж ирье.

4 дүгээр санал. 4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 43.4 дэх заалтын “энэ” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 38 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.Нэр дэвшигч нь сонгуулийн хуульд заасан цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлээгүй, бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Штаб чинь одоо юу болох вэ хуулийн этгээд болох уу тийм ээ? 6.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17 дүгээр, 13 гишүүн санал хураалтад оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 48 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд хуульд заасны дагуу төвлөрүүлж, зарцуулах талаар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ дэмжигдлээ.

Энэ түрүүн бид нар хураасан шүү дээ 3 дээр. 3 дээр хураасан. Энэ дээр юу яах хэрэгтэй юм байна шүү. Энийг бас тэнд дөрвөн мянга мөртөө дахиад арван мянган гээд харьцаа нь бас өөр байна шүү. Энийг анхаараарай бас. Дөчин мянга байх ёстой байх. Таван мянга гэвэл тавин мянгыг бас хураасан шүү дээ бид нар. Тэр дээр нэг, хоёр дахь санал дээр бас 75-г 74 гээд уншсан гэсэн үү? 75-аар ойлгож бас, юу гэсэн үг юм бэ? 74 гэж байх ёстой юм байна тийм үү. 74 гээд бичсэн юм байна шүү дээ тийм ээ. 75 гээд бичсэн юм байна шүү дээ. Тэгэхээр 74 гэж ойлгох юм байна шүү дээ тийм үү. За ингэж ойлголоо шүү.

7 дахь санал. 7.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 49 дэх хэсгийн “цуглуулах” гэснийг “цуглуулсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 8. 13 гишүүн санал хураалтад оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 39 хэсгийн “нийтэлсэн” гэсний дараа “, цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн” гэж, 40 дэх хэсгийн “Интернэтийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж, 50 дахь хэсгийн “бол” гэсний дараа “хууль бусаар зарцуулсан хөрөнгө, орлогыг хурааж” гэж тус тус нэмэх. Санал

гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

9 дүгээр санал. 9.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 54, 55, 56, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“54.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

55.Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглох бөгөөд зөрчвөл хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж зөрчсөн хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

56.Хандив өгөхийг хориглосон этгээд хандив өгсөн, авсан, хандив өгөхийг хориглосон этгээд болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

58.Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Найм.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.6” гэснийг “мөн зүйлийн 6.8” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд “1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт 17.1 дүгээр” гэж, төслийн 2 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 42 дахь хэсгийг хасаж, төслийн 1 дүгээр зүйлийн “41” гэсний ард “42” гэснийг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Анхааралтай гишүүдээ.

3.Төсөлд дараах агуулгатай 3 дугаар зүйлийг нэмэх:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.8.9.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүгч харьяалан шийдвэрлэх Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаа, тагнуул, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх бүхий албан тушаалтан, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, татварын улсын байцаагч гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Ес.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 7 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Одоо гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя.

Аюурсайхан гишүүн. 1.Төслийн 30 дугаар зүйлд 30,8 дахь хэсэг нэмэх:

“30.8.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” Энэ дээр Баасанхүү гишүүн бас түрүүн санал гаргаж байсан. Батзандан гишүүн бас санал гаргасан. Энэ тусад нь хураах уу? Батзандан гишүүн бол Эрүүгийн хуульд заасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг хүн амь, тагнуул, эх орноосоо урвах, авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэр дэвшүүлэхгүй гэсэн санал гаргасан байна. Баасанхүү гишүүн бол авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлана гэсэн байна.

Саналуудаа нэг мөр тайлбарлаад санал хураалгая. Батзандан гишүүний микрофон өгье.

Ж.Батзандан: Сонгуулийн хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан Шударга иргэдийн нэгдсэн эвслээс тодорхой саналуудыг гаргаж байгаа юм. Үүний нэг нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргүүдийг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгэл эдэлж байсан зарим нэг нөхдийг тухайлбал эх орноосоо урвах гэмт хэргийг үйлдсэн, тагнуул хийх гэмт хэргийг үйлдсэн, хүчингийн гэмт хэрэг үйлдсэн, хүн амины гэмт хэрэг үйлдсэн, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хүмүүсийг Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших эрхийг нь хязгаарлах нь зүйтэй гэж бид үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл өнөөдөр төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүсийн нэлээдгүй хүн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан, хүн амины хэрэг, авлага, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж дурд нь ял шийтгүүлж байсан иргэд нөхөд төрд ажиллаж байна.

Одоо хязгаарлалт хийх цаг нь болсон. Энэ бол Монголын ард түмний эрх ашиг, үндэсний эрх ашиг гэж бид ойлгож байна. Ямар нэгэн намын эрх ашгийн үүднээс урд нь гэмт хэрэг үйлдэж байсан нөхдийг сонгуульд нэр дэвшиж Улсын Их Хурал болон бүх шатны сонгуулиар Монгол төр рүү орж ирэхийг оруулж ирэхийг ШИНЭ намын эсэргүүцэж байна. Ийм учраас бидний саналаар санал хураалгаж өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Жаахан ялгаатай байгаа. Ирсэн дарааллаар хураачихъя. 1 дүгээрт нь Аюурсайхан гишүүнээс, 2 дугаарт нь Баасанхүү гишүүн, хамгийн сүүлд Батзандан гишүүнийх ирсэн. 3 янз. Эхлээд Аюурсайхан гишүүний саналаар санал хураалгая. Дараа нь Баасанхүү гишүүн тусад нь хураалгана. Хамгийн сүүлд нь Батзандан гишүүн хураалгана. Ойлгоорой. Тэгье. Аюурсайхан гишүүний санал Төслийн 30 дугаар зүйлд 30,8 дахь хэсэг нэмэх:

“30.8.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аюурсайхан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Ял эдэлж байгаа бол гэж орсон шүү дээ. Энэ санал дэмжигдлээ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо Баасанхүү гишүүний санал. Авлига албан тушаалын хэрэгтэй холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлана. Баасанхүү гишүүний санал. Эрдэнэбат гишүүн. Эрдэнэбат гишүүний дараа хэлчих Баасанхүү гишүүнээ.

Д.Эрдэнэбат: Энэ нэг сонин л юм яваад байгаа юм л даа. Үндсэн хуульд нэг ийм заалт байгаа. Бид одоо хуулийг л ягштал биелүүлэх ёстой. Хүний эрхийг хамгаалах ёстой гээд ингээд ухаандаа л бид нар чинь ардчилсан Монгол Улсын л иргэд шүү дээ. Үндсэн хуульд иргэн бүр сонгох, сонгогдох эрхтэй гэж байгаа юм. Энэ бол хатуу заагдсан заалт. Сонгогдох эрх гэдэг бол томилгооны албан тушаалтны шалгуураас шал өөр зүйл л дээ. Тэгээд би ойлгохдоо бол юу гэж ойлгож байна вэ гэхээр хэрэв тэр хүн ялаа эдлээд дууссан бол тэр хүн бол зүгээр л Монгол Улсын эрх чөлөөтэй л саналаа өгөх ч ёстой, сонгох ч ёстой ийм л иргэн гэж ойлгоод байгаа юм. Энэ уламжлалыг энэ Их Хурлын урд талын хуулиуд дээр дандаа баримталж ирсэн байхгүй юу. Баримталж ирсэн.

Тэгэхээр аливаа нэгэн гэмт хэрэгт нэг сайн гэмт хэрэг, муу гэмт хэрэг гэж байхгүй шүү дээ. Харин нэгэн дээр санал нэгдэж байгаа нь саяын томъёолол дээр жишээлбэл ял эдэлж байгаа бол шүүхийн шийдвэр гарсан бол гэдэг л бол зөв. Урд нь чи гэмт хэрэг үйлдэж байсан учраас сайн, муу гэмт хэрэг гээд ялгаад энэ нь болно, энэ нь болохгүй гээд энэ хүний сонгогдох эрх рүү Үндсэн хууль зөрчиж орж болохгүй л гэж би ингэж ойлгоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ дээр их нухацтай хандах ёстой юм болов уу? Ялгаварлалгүй байх л ёстой л доо. Аливаа нэгэн зүйлийг хийе гэж байгаа бол. Гэхдээ энэ бол Үндсэн хуулийнхаа нөгөө иргэн хүний сонгогдох, сонгох эрх рүү бол шууд халдсан зөрчилтэй заалт бол хувирчхаад байгаа юм. Тэгэхээр энийг бол бид нар бол дэмжих боломжгүй юм шиг санагдаад байх юм. Манай гишүүд юу гэж үзэж байгаа юм бэ? Томъёоллоо л их зөв хийх хэрэгтэй. Сая Аюурсайханых дээр бол арай өөр томъёолол орж ирж байна шүү дээ. Шүүхийн шийдвэр нь авлигал албан тушаалаар ингээд шүүхийн ял эдэлж байгаа бол гэдэг томъёолол бол байж болох заалт.

Ял эдэлж байсан гэдэг томьёолол бол маш буруу заалт. Би бол тэгж харж байгаа. Тэр хүн чинь ялаа эдлээд юу цагаатгана гэдэг юм уу яадаг юм бэ. Одоо чи одоо бүрэн хүмүүжлээ ч гэдэг юм уу нэг томьёолол байдаг даа. Ингээд гараад ирсэн хүнийг чи урд нь ялтай байсан байна. Чамайг сонгож болохгүй. Нэг эсхүл санал өгч болохгүй гэх юм бол наадах нь шууд Үндсэн хуулийн зөрчил рүү очих байхгүй юу. Би бол тэгж харж байна.

Тийм учраас энэ дээр бол би хувьдаа бол энэ дээр бол санал өгөх үнэхээр боломж байхгүй. Бид Үндсэн хуульд захирагдаад л энэ ардчилсан зарчмаа л баримтална. Ийм л юм байгаа юм.

С.Бямбацогт: Баасанхүү гишүүн саналаа тайлбарлаж үг хэлье.

О.Баасанхүү: Тэгэхээр ийм юм. Бид нар хууль тогтоох дээд байгууллага байгуулах гэж байгаа. Тэгэхээр 1 дүгээрт.

2 дугаарт юу вэ гэх юм бол эрх чөлөөтэй гээд байгаа юм л даа. Эрхтэй биш. Үндсэн хууль дээр эрх чөлөөтэй гэж байгаа юм. Эрх үүрэгтэй гэсэн үг. Эрх дээрээс нь үүрэг. Чөлөөтэй гэдэг үгийг тэгж орчуулж байгаа. Дээрээс нь хуулиар сонгуульд оролцох нөхцөл бололцоог Монгол Улсын Их Хурал тогтоодог. Жишээлбэл нас байж болж байна. Боловсрол байж болж байна. Энэ бүх болгон чинь янз бүрийн байдлаар хязгаарлах бололцоотой. Хэн ч өнөөдөр мэдээж насан туршдаа гэмт хэрэг хийсэн, хийлээ гээд чичлүүлж болохгүй. Энэ бол коммунист дэглэм.

Тэрэнтэй адилхан бол би бол энийг зөв гэж бодож байгаа юм. Харин албан тушаалын гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг бол тэр хүнийг төрийн дээд хууль тогтоох байгууллагад ороод хэрэггүй ээ. Тэр өөр байгууллагадаа орооч. Хуваариа ажлаа хийгээч. Заавал ингэж юу гэдэг юм энэ чинь Улсын Их Хурал хуулиар нэр дэвшигчийг оруулах гэж байгаа бол нам нь тийм хүмүүсээ битгий оруулаач гэсэн намд нь үүрэгжүүлж байгаа байхгүй юу. Хувь хүнд зориулсан ямар ч юм байхгүй. Нам өнөөдөр ямар ч хүнийг гаргаж болно гэх юм бол хууль гаргаад хэрэггүй шүү дээ.

Нам бол наад зах нь дээд боловсролтой байх ёстой гэж энд оруулах ёстой. Нам бол юу гэдэг юм тодорхой олны итгэл хүлээсэн авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдээгүй хүн байх ёстой гэж оруулах ёстой. Нам ёс зүйтэй хүнийг оруулах ёстой гэдгийг намд үүрэгжүүлж энэ заалтыг орууллаа би ойлгож байгаа. Би даагч ч гэсэн өнөөдөр би биеэ даагаад явъя гэдэг асуудал бас ороод ирэхийг үгүйсгэхгүй. Гэхдээ тэр 800 хүнд бас тэр хүн чинь 800 хүнээр бас ингээд ороод ирж болно шүү дээ. Тэгэхэд бас адилхан та 800-даа байхдаа авлига албан тушаалын биш хүнийг одоо нэр дэвшихийг, дэвшүүлээч гэсэн ийм үүрэгжилт өгч байгаа болохоос хувь хүн рүү хандаагүй.

Аюурсайханы тэр юуг бас мушгих магадлалтай юм байна гэж би хараад байгаа юм. Улсын Их Хурал тогтоодог байгууллага биш. Шүүхээр тогтоогдсон гэдэг чинь одоо ял эдэлж байгаа юу? Ер нь тогтоогдсон байсан уу гэдэг дээр маргаан үүсэх магадлалтай байна. Тийм учраас би энэ саналаа эхлээд батлуулчихаад зарчмын юугаар оруулж ир гэж. Одоо энэ төрөө цэвэршүүлье л дээ. Хүний нэр яримааргүй байна. Гэхдээ шулуухан хэлэхэд ингээд л дээр үед чинь гаалийн баатар гэдгээс эхлээд бид нар ярьдаг. Төрийн албанд янз бүрийн байдлаар зөндөө л хүмүүс орсон байна.

Тэгэхээр төрийн албаны тухай хуулийн зарчмыг л дагаж оруулж ирж байгаа заалт шүү дээ. Өөр юу байгаа юм бэ? Тийм учраас миний саналыг бас дэмжээд өгөөч гэсэн ийм зүйл байгаа. Ийм зүйл байгаа шүү. Зүгээр гэмт хэргийн маш олон төрөл байдаг. Санаатай, санамсаргүй, болгоомжгүй, залуу зандандаа хийгдсэн янз бүр байж болдог. Бид нар бол албан тушаал авлигыг төр рүү оруулахгүй байя гэж байгаа. Тэрнээс бусад дээр нь бид шүүгээд яах юм бэ? Тэр бол хувь хүний одоо нөхцөл байдлаасаа хамаарсан байхыг үгүйсгэхгүй. Энэ бол албан тушаалыг хашиж байхдаа хийсэн асуудал гэж хараад байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Саналын томъёоллыг би дахиад уншаад танилцуулъя. Авлига албан тушаалын хэрэгтэй холбоотой асуудлаар шүүхийн төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгууль нэр дэвших эрхийг хязгаарлана. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Түрүүн хэнээ Аюурсайхан гишүүний дэмжигдсэн санал бол авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно гэсэн байсан. Өөр үг хэлэх хүн байна уу? Оюун-Эрдэнэ гишүүн санал тасаллаа.

Л.Оюун-Эрдэнэ: Ийм зүгээр санал орж ирж байгаад бол бас бид нар нэг нухацтай ярих цаг болсон байгаа юм. Тэгэхээр бид нар яах вэ Үндсэн хуулийн эхийг ингээд аль, аль талаас нь тайлбарлаж болоод байдаг. Жишээ нь одоо энэ эрүүдэн шүүсэн гээд асуудал дээр болохоор хүний эрхийг ярихаар огт өөр талаас нь ингээд тайлбарласаар байгаад ингээд одоо 2, 3 жил явчхаж болдог. Тэгэнгүүт өөрсдөө сонгогдох болохоор энэ дээр ерөөсөө хязгаарлуулж болохгүй гээд байгаа. Сонгууль өгнө. Сонгогдох гэдэг бол бас 2 өөр агуулга. Сонгох эрхтэй байж бол болно.

Одоо бол яг чин үнэнийг хэлэхэд бид нар энэ дээр ямар нэгэн байдлаар хязгаарлалт одоо хийх ийм соёл руу явахгүй бол одоо энэ чинь Үндсэн хууль дээр ч гэсэн намууд дээр босго тавих ийм том соёлын өөрчлөлтийг бид нар хийчихлээ. Цаашлаад одоо бас нэг энд нэг шинэ өнгөрсөн 30 жилээ дүгнээд бас нэг хариуцлагатай шинэ 30 жилийг эхлүүлъя гээд Үндсэн хуулиа нэмэлт, өөрчлөлт бид нар хийчихлээ. Одоо энэ Их Хурал чинь яг шулуухан энэ нөгөө шүүхээр шийдэгдэх магадлалтай хүмүүсийн хорогдох цайз болчихоод байна.

Хэрэг хүмүүс одоо энд баахнаараа дэвшинэ харж байгаарай. Одоо яг энэ шүүх дээр явж байгаа энэ нөхдөөс их олон хүмүүс дэвшинэ гэдэг ийм мэдээлэл ирж байгаа. Яах гэж байна вэ гэсэн үг вэ? Хөөн хэлэлцэх хугацаа дуустал парламентын гишүүн болно гэсэн үг. Яаж ийж байгаад тохирч байгаад нөгөө нэг авлигынхаа мөнгөөр парламентад орж ирнэ. Ингээд яах вэ гэхээр хөөн хэлэлцэх хугацаан дээр бид нар маш гоёор манай ах нар бол өөртөө зориулаад Өршөөлийн хууль зохион байгуулсан.

Одоо тэгээд тэрнээсээ сайхан ингээд мултраад гадаадад гараад явчхаж байгаа. Одоо нэг 49-ийн хэрэгтэй холбоотой нэг хэдэн нөхөд байгаа. Бүгдээрээ гадаадад өвдлөө хавдлаа гээд ингээд алга болсон. Хамгаалагчаа авахгүй бултаж байгаа юм. Ингээд яах вэ гэхээр сонгууль дөхөөд хүрч ирнэ. Сонгууль дөхөж хүрч ирээд 1 сарын юм уу 14 хоногийн дотор гэнэт нэр дэвшинэ. Ингээд 4 жил, 4 жилийн дараа хөөн хэлэлцэх хугацаа байхгүй. Аягүй бол дахиад нэр дэвшинэ.

Тэгэхээр Их Хуралд цэгцэрч байж засаглал цэгцэрнэ. Засаглал цэгцэрч байж төрийн алба цэгцэрнэ. Төрийн алба цэгцэрч байж хувийн хэвшил нийгэм, энэ

бүх зүйл өөрөө цэгцэрнэ. Тэгэхээрээ эрх барих дээд байгууллага хууль тогтоох байгууллага Их Хурал мөн л юм бол бид нар энэ дээр ёс зүйн ямар нэгэн ийм шаардлагуудыг ярих цаг нь болсон. Тэгэхээр яах вэ энэ дээр мэдээж өөр, өөр талууд одоо ингээд хууль хяналтын байгууллагад улс төрийн хэрэг үүсгэнэ энэ тэр гээд ярьдаг л даа.

Гэхдээ хууль хяналтын байгууллага өөрсдөө оролцоод ийм асуудалд оролцоод өөрсдөө энэ хөөн хэлэлцэх хугацаа болон бусад асуудал дээр тоглолт хийгээд байгаа ийм соёл тогтоод байгаа нь хэн бүхний өмнө нүдэнд ойлгомжтой байна. Энэнээсээ болоод бид нар саарал жагсаалтад орлоо. Цаашлаад хар жагсаалт руу орох ийм нөхцөл байдал үүсэж байна.

Энэ дохио шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар Үндсэн хуулийн цэцтэй эд нар одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга яриад Их Хурлын удирдлагууд уулзаад гарцыг нь олж байгаад энэ 2 талаасаа ингээд ярьж байгаад энэ дээр нэг шийдэл гаргаж болдоггүй юм уу? Болохгүй гээд л харчихвал заавал болохгүй талаас нь ингээд тайлбарласаар байгаад л нэг гарчих гээд байх юм. Өөр зөндөө болох юмнуудыг бид нар хийсэн шүү дээ. Өршөөлийн хууль хүртэл батлаад өчнөөн их наяд төгрөг чөлөөлж авчхаад энийгээ болно гэж тайлбарлаад байдаг.

Яг одоо жишээлбэл сонгуультай холбоотой ийм асуудал ярихаар энийг Үндсэн хуулиар халхавчлаад байдаг. Ойлгож байна. Одоо хүний эрхтэй холбоотой асуудлыг. Гэхдээ энэ чинь эрх чөлөөний хажуугаар хариуцлага гэдэг нэг ийм зүйлийг бид нарын хувьд одоо ярих бол цаг нь болсон байх гэж бодож байна. Тийм учраас одоо Аюурсайхан гишүүн, Батзандан гишүүн, Баасанхүү гишүүн нарын ярьж байгаа яг энэ сэдлийг бол дэмжиж байна. Энэ бол цаг нь болсон асуудал шүү.

С.Бямбацогт: Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана шүү. Дараа нь Батзандан гишүүний саналаар бас яана тийм. Санал хурааа. Татчих юм уу? Адилхан юм чинь уг нь түрүүн дэмжигдсэн шүү дээ яах юм бэ? Дэмжье за. Санал хураалтад 13 гишүүн оролцож 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо энэ дээр би дахиад уншъя. Эмэгтэйчүүдийн, Батзандан гишүүний санал. Эмэгтэйчүүдийн эсрэг Эрүүгийн хуульд заасан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг, хүн амь, тагнуул, эх орноосоо урвах, авлига албан тушаалын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно. Хүн амины хэрэг гэж байна тийм. Батзандан гишүүн саналаа тайлбарлах уу? Энхболд гишүүн асуух юм уу? Энхболд гишүүн.

Н.Энхболд: Тэр нэг хязгаарлана гэдэг томьёоллоор санал хураачихлаа шүү дээ тийм ээ сая. Тэрийг юу гэж ойлгох юм бэ? Хагас дэвшүүлээд, хагас санал өгөөд явах юм уу хаашаа юм бэ? Тийм. үгүй ээ, үгүй тэр чинь хязгаарлана гээд л үгээрээ орсон бол? Тэрийг чинь тийм. Ер нь адилхан юм байна шүү дээ бараг тийм ээ? Гэхдээ тэрийгээ тодорхой болгохгүй бол болохгүй.

С.Бямбацогт: Ойлгосон. Баасанхүү гишүүн саналаа татах юм байна за.

Н.Энхболд: Ойлгомжгүй үг хуульд орж болохгүй шүү дээ тийм.

С.Бямбацогт: Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Баярлалаа. Би юу яая саналаа татаж авлаа. Яагаад саналаа татаж авч байгаа вэ гэхээр утга найруулга агуулгын хувьд давхардсан гэж үзсэн. Протоколд ч тэр тодорхой яригдсан. Зүгээр дараагийн хэрэв нэгдсэн чуулганаар дэмжигдвэл найруулгын тал дээр бас дахин анхаарах юм байна уу, үгүй юу гэдгийг манай Байнгын хорооны дарга чиглэл өгөөрэй.

С.Бямбацогт: Тийм ээ тийм. Санал гаргасан Баасанхүү гишүүн, Аюурсайхан гишүүн гээд явчихъя. Тэгээд тийм, Баасанхүү гишүүн хамт гаргасан шүү дээ. Тэгээд энийг нийлүүлээд хоёулаа дэмжигдсэн учраас найруулгын хувьд нэлээн үг үсгийн хувьд бас анхаараад явъя. Батзандан гишүүн саналаа тайлбарлая.

Ж.Батзандан: Ардчилсан Монгол Улсын үндсэн зарчим бол иргэдээ эрүүл аюулгүй орчинд амьдруулах, хүний эрхийг хамгаалах нь ардчилсан Монгол Улсын ардчиллын үндсэн зарчим юм. Хууль тогтоох байгууллагад нь авлигачид, охид хүүнүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн нөхөд, эх орны эсрэг тагнуул, эх орноосоо урвах гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, мөн хүн амины гэмт хэрэгтнүүд цуглаж болохгүй гэж бид нар үзэж байгаа юм.

Өнгөрсөн 30 жил бол Монголын төрд олон гэмт хэрэгтнүүд хуран цугласан 30 жил байсан юм. Ийм ардчилал гэж байдаггүй юм. Гэмт хэрэгтнүүдээр төрөө удирдуулж байгаа бол энэ энийг ардчилал биш, арчаагүй төр гэж нэрлэдэг юм. Ийм учраас сонгуулийн хуульд миний бие Аюурсайхан, Баасанхүү гишүүний саналыг дэмжихээс гадна нэмж 4 төрлийн гэмт хэргийг үйлдсэн хүмүүсийг Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших эрхийг нь хориглох ёстой гэж үзэж байгаа юм. 1 дүгээрт насанд хүрээгүй охидыг хүчиндсэн хүчингийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг.

Эрүүгийн хуульд маш тодорхой заасан байгаа. Хүчингийн гэмт хэрэг үйлдэж байсан нөхдийг Улсын Их Хуралд нэр дэвшихийг нь хориглох ёстой. 2 дугаарт хүн амины санаатай гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг. Алуурчдыг гэсэн үг. Улсын Их Хуралд нэр дэвшихийг нь хориглох ёстой. 3 дугаарт эх орноосоо урвах гэмт хэргийг үйлдсэн хүмүүсийг. Тагнуул хийх гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдийг. Авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдож шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял эдэлж байсан хүмүүсийг Улсын Их Хуралд нэр дэвших эрхийг нь хориглох ёстой гэдэг саналыг ШИНЭ намаас гаргаж байна. Дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

Энэ бол ардчиллын зарчим. Монгол Улсын иргэн бүр, эрүүл аюулгүй орчинд эрхээ хамгаалуулж амьдрах эрхтэй юм. Үүний төлөө энэ саналыг Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Батзандан гишүүн саналаа тайлбарлалаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 6 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал хураалт. Амарзаяа, Билэгт, Гарамжав, Мөнхцэцэг, Оюунчимэг, Оюундарь, Саранчимэг, Цогзолмаа, Оюунхорол, Ундармаа, Ундраа, Сарангэрэл нарын гаргасан санал. Хуулийн төслийн 31.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн гэснийг 31.2.нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 30-иас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгоё. Амарзаяа гишүүн саналаа хэлье.

Н.Амарзаяа: Зарчмын зөрүүтэй санал оруулсан. Эмэгтэй гишүүд. Тэгээд сая одоо манай гишүүд ярьж байна л даа. Тэр дундаа авлигын хэрэгтэй, хүчингийн хэрэгтэй, бас одоо маш олон асуудлаар тэр дундаа нэр дэвшихийг нь хориглоно гээд асуудал дэвшүүлээд бараг бас нэлээд заалтууд орж ирж дэмжигдэж байна л даа. Ер нь бол бас энэ асуудлын нөгөө тал нь юу вэ гэхээр эмэгтэй бас нэр дэвшигчид олноор бий болж, эмэгтэй гишүүд олноор бий болж нийгэмд энэ болохгүй, бүтэхгүй байгаа асуудлыг шийдвэрлэх энэ бас нэг эзэд нь бол эмэгтэй гишүүд. Эмэгтэйчүүд гэж ингэж үзэж ойлгож явдаг.

Тэгээд энэ ч утгаараа бид 1924 онд Бүгд найрамдах улсыг тунхаглаж анхны Үндсэн хуулиа баталж үүгээр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тэгш эрхтэй байх энэ боломжийг нь тунхагласан байж байгаа. Тэгээд Үндсэн хуульд тунхагласнаас хойш сая бид бас 19 оны Үндсэн хууль дээр ч гэсэн энэ зарчмын байр сууриа хадгалж, ингээд сонгох, сонгогдох эрхийг нь тэгш байдлаар эдлүүлэх, энэ боломжийн төлөө бас нээлттэй ийм боломжууд олгож байгаа. 16 оны сонгуульд бол анх удаа эмэгтэй нэр дэвшигчийн хүйсийн гэдгээр нь 23-аас доошгүй гэдгээр хуульчлаад харин Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд бол бүр 30 хувь, 40 хувь дээд тал нь 50 хувьд хүргэх ийм одоо амлалтыг өгсөн явж байгаа л даа.

Тэгэхээр 16 оны сонгуулийн дараа одоо 4 жилийн дараа зайлшгүй эмэгтэй нэр дэвшигчийг бас улс төрийн намууд ч гэсэн хүлээн зөвшөөрч хувийг нь нэмэгдүүлэх ийм шаардлага хэрэгцээ бидэнд байгаа учраас 30 хувь гэдэг энэ хувийг нэмэгдүүлж өгсөн энэ саналыг бол дэмжиж өгөөрэй гэж ингэж хүсэж байгаа юм.

С.Бямбацогт: Баасанхүү гишүүн. Ингээд үг тасалсан шүү.

О.Баасанхүү: Би бол зүгээр ингэж бодоод байгаа юм. Энэ эрэгтэй, эмэгтэй гэж одоо ингээд ялгаад эрэгтэй гэхээрээ давуу, эмэгтэй гэхээрээ сул гээд. Тэгээд эмэгтэйдээ сул дорой байгаа учраас оруулъя гээд. Ингээд эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийн эсрэг яриад байгаа юм шиг санагдаад байх юм. Аягүй сонирхолтой. Эмэгтэй хүн чинь одоо Ангела Меркель шиг ч юм уу, өөр энэ Финландын Ерөнхий сайд ч гэдэг юм уу эд нар квотоор орж ирээд л ингээд гарсан юм байдаг юм болов уу? Би бол мэдэхгүй байна. Яг ний нуугүй хэлэхэд эмэгтэйчүүдийн эрхийг гэж хэлчхээд эмэгтэйчүүдээ доош хийхээ больцгооё. Ер нь бол заавал одоо харийн тэрний оронд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ энэ дотор оруулах ёстой.

Угаасаа хууль дээр тодорхой байгаа шүү дээ Монгол Улсын хууль дээр. Аливаа байгууллага 5-аас доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орж ажиллуулна гэсэн байгаа юм. Бид тэгэхээр бас хуулиа дээдэлдэг гэдэг юу гэдэг юм жишгээ тогтоохын тулд 5 хүртэл хувийг гэдэг юм уу ядаж 2 хувийг энд оруулъя. Тэгээд ард түмэн сонгоно биз дээ. тэгэхээр энэ бол бараг эмэгтэйчүүдийн маань бол би юу гэж бодож байгаа вэ гэвэл одоо эмэгтэйчүүдийн хүмүүн төрөлхтний дундаас хөөрхий бүсгүй эмэгтэйчүүд гэж ярихаа бол одоо болиод. Харин миний энэ саналыг дэмжээч гэж уриалмаар байна.

С.Бямбацогт: Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Саналыг нь уншсан. 30 хувь болгоё гэсэн. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 5 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал хураалт. 20-иос доошгүй 80 хүртэл байж болно шүү дээ.

Баасанхүү гишүүний санал. Бүх шатны сонгуульд оролцохдоо өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байгаа этгээд нь Сонгуулийн хууль тогтоомжийг талаарх шүүхийн төгөлдөр гарч байсан бол сонгуульд, энэ уншсан санал байна шүү дээ Бямбаа минь. Одоо дахин санал бичиж өгөхгүй. Одоо санал яасан шүү. Бүх шатны сонгуульд оролцохдоо өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд оролцох эрхийг хориглоно. Ерөнхийдөө ойлгомжтой юм байна шүү дээ. Сонгуулийн штабт ажиллаж байсан хүмүүс мөнгө төгрөг тараагаад янз янзын асуудал гарчээ, шүүхийн шийдвэр гарч байсан бол тэр хүнийг оролцуулахгүй гэж байна шүү дээ тийм ээ? Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Шүүхээр тогтоогдсон бол хориглоно гэсэн үг. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 4 гишүүний санал энэ дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар татагдсан нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн тохиолдолд сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлана. Санал гаргасан Баасанхүү гишүүн. Санал тайлбарлая 1 минут. 1 минут өгье. Баасанхүү гишүүнд минут.

О.Баасанхүү: Би ингэх гээд байна. Одоо бол Улсын ерөнхий прокурор Монгол Улсын ерөнхий прокурор одоо Сонгуулийн ерөнхий хороо руу зарим нэг хүмүүсийг оруулж ирж магадгүй. Жишээлбэл нөгөө саяын айгаад нөгөө Сайханбилэг ч байдаг юм уу, одоо хэлээд байна шүү дээ. Энэ хүмүүсийн асуудлыг оруулж ирмээргүй байна. Энэ бол сэжигтэн ялагчаар татагдсан. Тийм учраас ийм хүмүүсийг бол нэр дэвших ёсгүй. Яагаад гэвэл гэм буруутай, гэм буруугүйгээ шүүхээр тогтоолгох үүрэгтэй гээд ингээд хэлээд аваад үлдээч ээ л гээд байгаа юм би. Тэгэхгүй бол одоо нөгөө сая Оюун-Эрдэнийн яриад байсны чинь эсрэг юм болчих гээд байна шүү дээ. Юу вэ гэвэл шүүхийн шийдвэр гараагүй. Шүүхийн шийдвэр гараагүй.

Тийм учраас юунаас нь би ямар гэм буруутай юу гээд л. Бүтэн 4 жил ярьсан нөгөө МАНАН мафийн эсрэг тэмцлийг чинь л баталгаажуулж өгч байна шүү дээ. Баахан л яриад байсан биз дээ. Одоо тэгээд ... /минут дуусав/

С.Бямбацогт: Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 6 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Пүрэвдорж гишүүний гаргасан санал. Төслийн 70.2 дахь хэсгийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна гэсний дараа мэдээлэл, технологийн багийн гишүүн, даамал нь санал авах тоолох төхөөрөмжөөс 4 метрээс багагүй зайд байрлаж төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж ажиллана гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх. Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлаад үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь бол яг энэ дээр чинь ихэнх нь төрийн албан хаагч ажилладаг. Тэгээд бүгдээрээ төрийн албан хаагч ажиллаж байгаа. Тэгээд энэ төрийн албан хаагч нар чинь бас тодорхой хэмжээгээр яг ялангуяа орон нутагт суман дээр бол маш их тийм нөлөө бүхий этгээд байж байдаг. Тэр хүмүүс ер нь бол энэ тодорхой үүрэг чиглэлийн дагуу хүмүүсийн саналын хуудсыг харж байгаад

хаана санал өгсөн, яасан ийсэн гэдгийг нь мэдэгддэг. Хүний нууцад халддаг ийм зүйл гараад байдаг юм.

Тийм учраас энэ заалт бол урд талын Сонгуулийн хууль дээр байсан заалт. Энэ ажлын хэсэг дээр уначих шиг болсон. Энэ манай Ардчилсан намаас одоо зөвлөлөөс оруулсан санал. Энэ хуучин заалт дээр Сонгуулийн хууль дээр байсан. Тийм учраас тэгээд энийг одоо буцааж нэмж оруулж өгөөч. Тэгэхгүй бол энэ яг сонгогчийн эрхэд халдсан. Өөрөөр хэлбэл нэг жаахан ойроос 2 метр, 1 метрээс нөгөө хүнийхээ одоо санал хаана өгч байгааг нь хараад тэгээд дараа нь тэр хүний эрхэд халдах иймэрхүү нөхцөл байдал тулгарах учраас энэ дээр бас Их Хурлын гишүүд дэмжиж саналаа өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Энхболд гишүүнээр үг тасаллаа.

Н.Энхболд: Хуучин хуульд тийм заалт байсан уу та?

С.Бямбацогт: Хуучин хуульд ийм заалт байсан.

С.Бямбацогт: Дахиад нэг унших даа яг саяынхыг.

С.Бямбацогт: Хуучин хуульд байсан заалтыг өргөн барихдаа хасаад өргөн барьсан. Ажлын хэсэг энэ санал яригдаагүй тийм. Би уншаад өгье. Хуучин хуулийн 91.1.1 дээр санал авах тоолох төхөөрөмжөөс 4 метрээс багагүй зайд байрлаж санал авах тоолох төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянаж ажиллана гэсэн ийм заалт байсан юм байна лээ. Тийм 2015 оны хууль дээр. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийнх нь хаана байна вэ? Дуусаагүй байна. Дахиад Пүрэвдорж гишүүний санал. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу сонгогчдын нэрсийн жагсаалтын сонгогчийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг бүхий хэсгийг зөвхөн цахим хэлбэрээр нэг удаа олгоно. Энийг хасагдсан байгаа тийм ээ? Энэтэй холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Ажлын хэсэг тайлбарлаад үг хэлэх үү тийм ээ? Сонгуулийн ерөнхий хороо тайлбарлаж үг хэлье. Бэлдэж байгаарай. Эхлээд хэн Баасандорж бүртгэлийн байгууллага. Пүрэвдорж гишүүн тайлбарлаад үгээ хэлчих. Дараа нь хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр өнөөдөр яг энэ ялангуяа жижиг намууд дээрээс нь сөрөг хүчний хувьд бол энэ сонгогчдын нэрсийн жагсаалтыг авах бол маш асуудалтай байгаа. Эрх баригч нар бол ямар нэгэн байдлаар асуудлаа шийдэж болох байх л даа. Тэгэхээр ер нь бол энэ дээр би Баасандоржийн тайлбарыг би мэдэж байна. Өөрөөр хэлбэл одоо энэ сонгогчдын нэр, регистр энэ мэдээлэл бол хязгаартай мэдээлэлд орж байгаа. Тийм учраас хаалттай гэж хэлэх гэж байгаа байх.

Гэхдээ наадах энэ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.3-т ингэж заасан байгаа. Бусад хуульд заагаагүй бол гэж. Хуулиар өөрөөр заагаагүй бол гэж. Тэгэхээр энэ наадах чинь болохоор энэ та болохоор энэ Улсын бүртгэлийн хуулийг яриад байгаа юм. Гэтэл наадах яг энэ заалтын дагуу та бол Прокурорын тухай хуулиар, Шүүхийн тухай хуулиар одоо юу байдаг юм янз янзын хуулиар энэ мэдээллийг авах эрхтэй гэж зааж байгаа юм. Тэгсэн мөртөө энэ Сонгуулийн хууль адилхан л одоо бусад хууль гэдгээр орох ёстой байхгүй юу.

Гэтэл энийгээ одоо Сонгуулийн хуулиар болохгүй гэж ийм тайлбар өгөөд байгаа. Тэгэхээр энэ бол түрүүний ер нь бол энэ сонгогчдын нэр энэ регистр энэ тэр бол хуучин ч гэсэн бас хаалттай мэдээлэлд ордог байсан. Энийг нь одоо 2016 оны Сонгуулийн тухай хуулиар энэ сонгогчдын нэрсийн жагсаалтыг нам эвсэлд өгөхөөр одоо ийм хуулийн заалт ороод тэрнийгээ хэрэгжүүлсэн. Өнөөдөр бүх намуудад энэ 16 он хүртэл сонгогчдын нэрсийн жагсаалт бүгдээрээ байж байгаа. 16 оноос хойш сонгох эрхтэй болсон тэр хүмүүсийн нэрс л дутуу байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бол энэ бүх мэдээлэл бүгдээрээ ил солон гэсэн үг.

Тэгэхээр энэ ер нь бол намуудад тэгш боломж олгох, илүү асуудлыг нягталж үзэх ийм шаардлага гарч байгаа. 2008 оны энэ 7 сарын 01-ний тэр одоо асуудал чинь хамгийн гол нь нэрсийн жагсаалт нь тодорхой биш. Хүмүүс царцаа байдлаар энэ тэнд очиж санал өгсөн хэд дахин дараалан санал өгсөн гэдэг ийм харанхуй мэдээллээс болж л энэ асуудал гарсан шүү дээ. Тийм учраас энэ сонгогчдын нэрсийн жагсаалтыг нь өгөөд за манай сум дээр тэдэн хүн байгаа юм. Манай дүүрэг дээр хэдэн хүн байгаа юм байна. Энэ хүмүүс ингэж санал өгөх юм байна гэдгээ тэрнийгээ ил болгоод ингээд явчих юм бол илүү хүмүүст энэ сонгуулийн үйл явц ил тод боллоо гэсэн тийм одоо хардалт байхгүй болно л гэсэн тийм л саналтай байгаа. Тийм учраас энэ саналыг дэмжиж өгөөч гэж гишүүдээсээ хүсэж байна.

С.Бямбацогт: Тайлбар бас тайлбар авчих нь зөв байх. Манай сонгууль зохион байгуулах, сонгуулийн бас тодорхой зохион байгуулалттай холбоотойгоор ямар нэгэн үр дагавар гарах юм бол энэ байгууллагууд хариуцах ёстой. Тийм болохоор хуулийн дагуу сонгууль зохион байгуулах, хуулиар хүлээсэн үүрэгтэй улсууд энд сууж байгаа. Тэгээд Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн байгууллага хариулт өгье. Хэн бэ эхлээд? Болдсайхан дарга Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга.

Ц.Болдсайхан: Одоо мөрдөж байгаа хуулийн 61.17-д байгаа юм л даа. Санал авах байрны албан ажлын хэрэгцээнээс бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах тараахыг хориглоно гээд. Энэ нь одоо өргөн барьсан ч байж байгаа. 61.18-д түрүүн Пүрэвдорж гишүүний хэлдэг намуудад нэг удаа цахим хэлбэрээр олгоно гэж. Тэгэхээр энэ дээр ер нь 16 оны сонгуулиар олгосон. Гэтэл энэ 2 заалт бол хоорондоо би бол хувьдаа ойлгохдоо зөрчилдөж байна гэж ойлгоод байгаа юм. Намууд энэ CD-ээр ингээд өгчхөж байгаа шүү дээ. Цахим хэлбэрээр. Энийг чинь бүгд хувилаад хүмүүс нь бариад айлуудын гэрээр яваад танайд энэ хүн байна уу гээд ингээд энэнээс болоод Сонгуулийн ерөнхий хороон дээр нэлээн гомдол ирсэн байхгүй юу.

Хүний нууцыг та нар яахаараа та нар тараадаг юм бэ. Регистрийн дугаартай, гэрийн хаягтай ингээд. Намууд ер нь энэ нэрийг авах гээд байгааг би үнэндээ ойлгохгүй байгаа юм. Ийм юманд л ашиглах гэж л авч байгаа л гэж ойлгож байгаа шүү дээ. Ер нь энийг авах ямар шаардлагатай юм бэ. Энэ Улсын бүртгэлийн байгууллага нь өөрсдөө ингээд гаргаад л ингээд л. Энэ бол 16 онд ийм байдлаар айл айлаар хувилж олшруулахыг хориглоно гэсэн CD-ээр өгсөн юм чинь тэрийг нь чөлөөтэй хувилаад л бүр хэсэг хэсгээр нь хувилаад л хүмүүст тараагаад л тэгээд ажилтнууд нь нам намаараа бариад л айл айлаар явсан юм маш их гарсан шүү дээ. Регистрийн дугаар бүх юм нь байгаа.

Тийм учраас ажлын хэсэгтэй яриад энэ бол шаардлагагүй юм гээд оруулаагүй юм байгаа юм.

С.Бямбацогт: Бүртгэлийн байгууллага. Бас хуульдаа нэмэлт, өөрчлөлт ороод бас ингэсэн гэсэн шүү дээ тийм ээ бас нэмээд тайлбарлаад, хариулт хэлье.

Б.Баасандорж: Баасандорж Улсын бүртгэлийн ерөнхий газар. Сая Болдсайхан дарга бол 1 дэх үндэслэлийг хэллээ. Хуулийн төсөл боловсруулахад гол үндсэн зүйл нь бол тэр иргэдээс маш их гомдол Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн гэсэн ийм хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл маш ихээр задарч байна гэдэг нэг үндэслэл. Энэ үүднээсээ хуулийн төсөл өргөн барихад энэ намуудад нэрийн жагсаалт өгөх асуудал бол хасагдаж орж ирсэн байна лээ.

Харин 2015 оны 12 сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуулиар сая Болдсайхан даргын хэлсэн тэр 61.18-аар Улсын бүртгэлийн байгууллага сонгуульд оролцож байгаа намуудад нэг удаа нэрсийн жагсаалтыг өгдөг байсан. Одоо гишүүдийн хэлэлцэж байгаа хуулийн төсөл дээр бол энэ хасагдсан байгаа юм. Энэ бол энэ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.6 дээр байгаа юм. Энэ 12.6 дээр бол тухайн энэ бол хязгаартай мэдээлэл. Хязгаартай мэдээллийг шүүхийн шийдвэрээр эсхүл прокурорын зөвшөөрлөөр цагдаагийн байгууллагад өгдөг.

Нэг бол тухайн иргэн хуулийн этгээдийн өөрийн зөвшөөрлөөр л тухайн иргэнтэй холбоотой энэ хязгаартай мэдээллийг өгнө шүү гэдгийг 2018 оны 6 сарын 21-нд хууль тогтоогчид энэ хуулийг баталж өгсөн байгаа юм. Тийм энэ бол яг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хувь хүний нууцтай холбоотой зарчим байгаа юм. Харин хувьд хүн өөртэйгөө холбоотой сонгуульд оролцохдоо мэдээллээ өөрийнхөө мэдээллийг харах боломж нь энэ Сонгуулийн хууль болон манай хуулиар бүрэн нээлттэй байгаа. Өөрт хамааралтай мэдээллээ харах нь.

С.Бямбацогт: Сая тайлбар хийсэн. Санал гаргаж тайлбар хийсэн. Асуулт биш саналаа тайлбарлаж үг хэлэх дэгтэй. Санал хураалт. 1 минут саналаа тайлбарлаад үг хэлье. Санал хураалтыг хүчингүй болгоё. Пүрэвдорж гишүүн. Санал хураалтыг хүчингүй болгоё. Ганц минут саналаа тайлбарлаад үг хэлье.

Б.Пүрэвдорж: Хуульд өөрөөр заагаагүй гэдэг нэрийн доор өөрөөр хэлбэл прокурор янз янзын хуулиудыг хэлээд байна шүү дээ. Тэгэхээр энэ Сонгуулийн хуулиар өөрөөр хэлбэл энэ нэрсийн жагсаалтыг хэвлэж өгөх тухай асуудал ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь энэ адилхан л органик хуулиуд нэгэндээ өөрөөр хэлбэл хуульд өөрөөр заасан гэдэг нь энэ Сонгуулийн хуулиараа энэ жагсаалтыг өгөх боломжийг нь нээж өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Сонгуулийн тухай хуульд орууллаа гэхэд энэ асуудал ямар ч тийм одоо хуулийн зөрчил бий болохгүй гэдгийг бас дахиж хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Санал хураалт явуулъя. Уг нь дэмжье гэж бодож байсан юм гээч. Санал хураалтад 13 гишүүнээс 2 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Батзандан, Болд нарын гишүүдийн санал. Нийт нэр дэвшигчийн 5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ чинь одоо байхгүй бол яах юм бэ, дэвшихгүй гээд байвал яах юм бэ? Хүчээр олж дэвшүүлэх юм уу? Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 3 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Баасанхүү гишүүн. Төслийн 31.2-ын аль нэг хүйсийн дараа 2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж нэмэх. Хураасан сая. Саналаа тайлбарлаад үг хэлье. Сая хураагаад унасан.

О.Баасанхүү: Баярлалаа. Би ийм л юм хэлээд байгаа шүү дээ. Монгол Улсын төр хуулиа дагах ёстой. Төрийн хууль дээр юу гэж байдаг вэ гэвэл аливаа байгууллага заавал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах үүрэгтэй нийт ажилчдынхаа хэмжээгээр гэж. Энийг 1 дүгээрт үлгэрлэх, 2 дугаарт нь хөгжлийн бэрхшээлтэй гэдэг чинь бид нараас илүү хөгжилтэй гэсэн үг байх үндэслэлтэй шүү дээ. Ямар нэгэн байдлаар. Олимпын аварга өнөөдөр пара-олимпын аварга гээд хүн байж л байна. Энэ тэнд юу гэдэг юм янз бүрийн юм хийсэн хүмүүс байж байна. Хараагүй хүн байж байна, сонсголгүй хүн байна.

Гэхдээ эцсийн эцэст тэр иргэд нь өнөөдөр сонгож л байгаа бол энэ нэр дэвших эрхийг нь ингэж хасаж болохгүй шүү дээ. Эмэгтэйчүүдийн гэхээр та нар зүгээр эмэгтэй хүн олон юм даа гээд сонгоод байж оруулж байгаа мөртөө хөгжлийн бэрхшээлтэй гэхээр энэ тоо нь цөөхөн юм даа гэж болохгүй байхгүй юу даа. Тэдэндээ урам зориг өгөх ёстой. Энэ ерөөсөө тэгвэл эмэгтэйчүүд ч чөлөөтэй шүү дээ. Эмэгтэйчүүд чөлөөтэй. Үүрэгжүүлж өгөхгүй болохгүй байхгүй юу. Өөрсдөө болохоор эмэгтэй хүн, эх хүн байж та нар яасан харгис юм бэ. Саажилттай хүүхэдтэй хүмүүс ямар байдгийг та нар мэдэх үү. Саажилттай гэдэг чинь тэнэг гэсэн үг биш. Харахад сонин бид нараас арай өөр харагддаг ч гэсэн бодитоороо цоо эрүүл биднээс ч илүү л байдаг байхгүй юу даа. Мэдлэг, боловсрол, өөрийгөө дайчилж байгаа байдлаар.

Тийм учраас миний хэлээд байгаа хамгийн чухал санал бол эмэгтэйчүүд яах вэ эмэгтэйчүүд чөлөөтэй гүйж очоод саналаа өгч болно. Эрчүүдээс ч илүү оролцъя явъя гэхэд энэ хүндлээд. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг очоод бүртгүүлье барья гэхээр болдоггүй шүү дээ. Тэгвэл тэр сэтгэцийн гэдэг юмаа оруул л даа. Тэгж л их юу яагаад байгаа юм бол. Сэтгэцийн эмгэгийг нь шалгуулна гээд. Энэ дотор өнөөдөр миний хэлж байгаа хэрэв ... /минут дуусав/

С.Бямбацогт: Баасанхүү гишүүнээ Сонгуулийн хуулийн 5 дугаар зүйл дээр байж байгаа. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх. 5.1.сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгогдох эрхтэй гээд ингээд орсон. Ийм юм дээр одоо хоёрын хооронд улс төр хийгээд хэрэггүй ээ. Санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 4 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. 67.5 дахь хэсгийн хийсний дараа гэсний дараа баруун долоовор хуруун дээр санал өгсөн гэсэн тэмдэглэгээ хийх гэж нэмэх. Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлая. Пүрэвдорж гишүүний санал.

Б.Пүрэвдорж: Ер нь бол Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хэлж байгаагаар бол ямар нэгэн гарын хурууны хээ, биеийн давхцахгүй өгөгдөл бол ямар ч тохиолдолд гацахгүйгээр ажиллана гэж яриад байгаа л даа. Тэгэхээр ер нь бол би энэ хурууны хээ бүртгэлийг ер нь offline түвшинд жишээ нь санал хураалт явагдаж байгаа тэр хэсгүүд дээр энэ нөхцөлд хурууны хээг юу тэмдэглэх ёстой гэдэг энэ өөрөөр хэлбэл хар бэхээр тэмдэглээд ингээд явах юм бол илүү асуудал найдвартай түвшинд бий болох байх гэж үзэж байгаа юм л даа.

Тэгэхээр ер нь бол яах вэ хурууны хээгээр уншуулж байгаа тохиолдолд зөвхөн тэр улсын бүртгэлийн ажилтан ч юм уу, аль эсхүл яг тэр хурууны хээг

уншуулж байгаа сонгуулийн ажилтан тэр асуудлыг хянана уу гэхээс тэнд сууж байгаа ажиглагч бол тэр хавьд юу болоод байгааг бол мэдэх тийм боломж байхгүй л даа. Тэгэхээр энэ хурууны хээгээ ингээд түрхээд юм түрхээд явчих юм бол алсаас хараад ямар ч байсан энэ нөхөр бол санал урд нь бол юу байдаг юм өгсөн байсан байна. Одоо энэ дахиж орох гэж байна гэдгийг тухайн ажиглагч мэдээд бас асуудал тавих ийм боломжийг нь бүрдүүлнэ гэж хараад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ ямар нэгэн байдлаар энэ хумс дээр ч юм уу ямар энэ хуруун дээр тэмдэглэгээ хийх нь бол ялангуяа хүмүүсийн янз бүрийн хардлагаас хамгаалах хамгийн чухал зүйл болох юм болов уу гэж харж байгаа. Тийм учраас энэ дээр гишүүд дэмжиж санал өгөөч. Энэ бол манай намын зөвлөлөөс өгсөн саналуудын нэг. Ажлын хэсэг дээр унасан байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр бас энэ хардлага энэ унасан бөхөд шалтаг мунадахгүй гэж ярьдаг шүү дээ тийм ээ. Тийм болохоор ямар нэг л хардах сэрдэх тийм барьц сэжүүр өгөх л юм бол тэр чинь бас эргүүлээд л нөгөө сонгуулийн дүнг будилаантуулах тэгээд дараа нь сонгуулийн дараа нь сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх гээд хэл ам бол гардаг. Тийм болохоор уг нь тэр бэх нь байдаг бол байлгаад ингээд хурууны хээгээр тэмдэглэж болохгүй юм уу? Яг баталгаатай ерөөсөө ингээд санал давхардуулж өгөхгүй, 1 иргэн, 2 газар очиж санал өгөхгүй байх бололцоо боломж бүрдсэн юм уу? Бэхээр тэмдэглэх гэхээр яагаад болохгүй байгаа юм бэ, бас нэг ажлын хэсэг дахиад нэг тайлбар авъя. Яагаад гэвэл дараа нь ингээд зориуд сонгуулийг будилаантуулах гэж эд нар ингээд хурууны хээгээр бэхээр тэмдэглэдгийг болиуллаа. Ингээд үндсэндээ бол хууль бусаар л Засгийн эрх авах гээд энэ Ардын нам олонхоороо түрж байна гэдэг байдлаар мушгиж явна шүү дээ. Ийм хардлага сэрдлэг төрүүлэхгүйн үүднээс уг нь харгүй сэргүй сайхан шударга сонгуулиа явуулчихмаар байна. Энэ дээр Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар дахиад нэг бас хариулт өгөөч.

Ч.Содномцэрэн: Асуултад хариулъя. Хурууны хумс дээр бэхээр тэмдэглэдэг энэ тэмдэглэгээ бол өмнө нь байсан. 2012 оноос хойш хурууны гарын хурууны хээгээр сонгогчийг бүртгэдэг болсноос хойш бол энэ хэрэглэхээ больсон. Өмнөх нь жилүүдэд бол манайх бол энэ хурууны хээний бэхийг бол хумсны тэмдэглэгээ хийдэг бэхийг Энэтхэг Улсаас авч байсан юм байна лээ. Тэгээд бид 2017 онд нэг авах шаардлага гараад энэ жагсаал болоод ингээд тэр Энэтхэгийн Элчин сайдын яам руу хандсан чинь энэ үйлдвэр нь хаагдсан байна. 17 онд. Энэ үйлдвэр нь хаагдсан байна. Монгол, Афганистан хоёр авдаг байсан юм байна. Тэгээд энэ 8 оноос хойш авахаа байсан учраас энэ бэхийг үйлдвэрлэхээ байсан байна.

Тэгээд яах вэ агуулахад байгаа нэг ганц, хоёр хайрцаг бэх байна. Тэр нь бол одоо яахын түрхээд юу гарах юм уу үгүй юм уу мэдэхгүй гээд. Ингээд нэг бэхээ 2 хайрцаг агуулахад байгаа бэхээ оллоо. Тэгсэн чинь олон тээврээр энийг тээвэрлэхийг хориглосон юм байна 2 дугаарт нь. Арай гэж нэг Солонгост авчирсан чинь каргогоор авчирсан чинь Солонгосын нутаг дэвсгэр дээгүүр химийн хортой бодис тээвэрлүүлэхгүй гээд ийм юу гарсан. Ингээд бол хүнд байдалд орсон 2 дугаарт.

3 дугаарт нь тэгээд яах вэ КАЛ-н удирдлагатай манай Элчин сайдын яам ярьж байгаад нэг юм тэгээд үндсэндээ олон улсын гэрээ хэлэлцээрийг нь зорчиж байж нэг юм оруулж ирсэн. Дараа нь яасан гэсэн чинь гар түлэгдсэн, хөл түлэгдсэн гэсэн гомдлууд ирсэн. Зурагтайгаа шүүхийн одоо юутай. 3 дахь нь бол энэ байсан.

Нөхөн олговор олгож өг гэсэн. Тэгээд Сонгуулийн ерөнхий хороо хуралдаж байгаад Нийслэлийн сонгуулийн хороонд тэр нөхөн олговрыг нь олгох шийдвэр гаргаж өгч байсан. Яасан бэ гэсэн чинь энэ нөгөө харшилтай улсуудад бол реакци үзүүлж байна.

Гар дээрээ тэмдэглэгээ хийлгэх гэж байгаа сонгуулийн хэсгийн хорооны ажилтан асгасан чинь энийг нь өм авсан байна. Хөл дээрээ тусаасан чинь өмөрсөн байна гээд. Зурагтай нь явуулсан. Ийм бэхийг бол манайхаас өөр орон хэрэглэхээ байсан юм байна лээ. Энэ аюултай бодис гээд. Тээвэрлүүлэхээ ч байсан. Одоо энийг олно гэхэд бол хэцүү. Бид нар химийн хүрээлэнтэй ярьсан бол ийм бэх үйлдвэрлэх түүхий эд материал байхгүй, боломжгүй гэсэн хариу өгч байсан Монголд. Орост байхгүй. Хятад угаасаа энийг үйлдвэрлэдэггүй гэсэн ийм хариу өгч байсан.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо хангалттай боллоо шүү дээ. 13 онд тийм үү Ардчилсан нам олонх байхад Ерөнхийлөгчийн сонгууль тэмдэглэхгүй явсан байна. 16 онд Ардчилсан нам олонх байх үед тэмдэглэхгүй явсан байна. Тэгээд тэрнээс гадна одоо энэ хурууны хээ гэдэг юм уу биеийн давхцахгүй хэн ч хэзээ ч давхцахгүй өгөгдлөөр санал өгөөд болдог болсон байгаад байна шүү дээ. Тэгээд боломжгүй ингээд байж байхад заавал нэг шалтаг гаргаж ярих гээд байх юм ерөөсөө. Дэгийн дагуу та саналаа тайлбарлаад үг хэлсэн. Санал хураалт. Санал хураалтад 12 оролцсоноос 4 гишүүний саналаар энэ дэмжигдсэнгүй. Саналаа тайлбарлаж үг хэлдэг дэгтэй. Гишүүд гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэх дэгтэй. Нямаа Энхболд гишүүн. Өөр анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулж хэлэх үгтэй гишүүд байвал кнопоо дарчих. Хураасан шүү дээ. Тасаллаа. Яах вэ бас үг хэлүүлье.

Жаахан суумаар байгаа юм шиг байна. Нямаагийн Энхболд гишүүн эхлээд үг хэлье.

Н.Энхболд: Би энэ нэг ийм юм хэлэх гэсэн юм. 21.6.4, 6.5 Бямбацогт даргаа манай ажлын хэсгийнхэн анхаараарай. 21.6.4, 6.5, 6.6 дээр ийм үгнүүд орчихсон байна. Урд нь байхгүй байсан юм. Бид нар бас анзааралгүй л явуулсан юм байна. Энэ цэргийн анги, хилийн анги нөгөө алслагдсан газруудад оршин сууж байгаа тэгээд тэндээ байнга оршин суух бүртгэлгүй боловч санал авах өдөр тухайн анги салбарт алба хааж байгаа албан хаагч, ажилтан гэж байсан хуучин миний санаж байгаагаар хуульд.

Тэгсэн энэ дээр одоо дахиад тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын мэдээллийг гэж 1 дүгээрт томьёолол нь гэр бүлийн сонгогч юу юм бэ гэдэг нь сонин байгаа. Хоёрт гэр бүлийн гишүүд гэвэл энэ чинь нөгөө хуулийн дагуу тэгээд л хамаатан садан хүртэл бүх юм ороод явчихаар ийм болчихож. Тэгэхээр хуучнаараа ерөөсөө тэр ангид алба хааж байгаа албан хаагч ажилтан л тэндээ нөгөө тусгай арай тусгай журмаар саналаа өгөөд авчирдаг. Бусад нь бол байгаа, байгаа газраа өгдөг юмыг хийхгүй бол энэ их олон юм улс орон даяар аваад үзвэл бас нэлээн их нааш цаашаа олон хүн амьтан зөөх, барих. Тэгээд авчрахгүй бол хэрэггүй мэдээлэл тэнд цуглах гээд ийм үр дагавартай юм болчихож. Энийг хэдүүлээ миний саналаар тэр тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын мэдээлэл гэдгийг нь л аваад хаячихвал болмоор байх юм. Энийг дахиж санал хураах уу, эсхүл ойлголцоод тэрийг нь хасчих уу? Энэ дээр миний ярьж байгаа зөв үү та нар би буруу ч ярьсан байж магадгүй. Санаа оноо байвал бас нэмэрлээч.

С.Бямбацогт: Ерөнхийдөө бид одоо хэлэлцүүлгийн явцад нягтлаад маргааш санал хураагаад хэрэв асуудалтай байх юм бол хуралдаан даргалагчаас чиглэл аваад эцсийн хэлэлцүүлэгтэй анхаараад явъя.

Н.Энхболд: Би тэгвэл хурал дээр бас үгээ хэлье.

С.Бямбацогт: Бас хэлье тийм ээ. За тэгье. Оюун-Эрдэнэ гишүүн.

Н.Энхболд: Би үгээ хэлж дуусаагүй байх юм. Тийм.

С.Бямбацогт: Энхболд гишүүн.

Н.Энхболд: Би нэг Байнгын хороо эд нар дэгтэй шиг санагдаад байх юм. Ингээд л хурал эхлэхээс өмнө бичгээр өгөөд саналаа өгөөд явдаг шиг үгүй билүү? Сууж байгаад л санаандаа юм орж ирэхээр бичиж өгөөд байдаг билүү, хурал нэлээн тийм замбараагүй л болох юм шиг харагдаад байх юм. Тийм. Тэгээд л хамгийн одоо хүний чихэнд наалдах тийм саналуудыг гаргаад л тэгээд ийм юмнууд болоод байх юм. Ер нь зүгээр би түрүүн нэг хэлсэн. Би одоо энэ заримдаа хуульчдаа ч ойлгохоо байлаа гэж. Аливаа юманд байна шүү дээ нэг тийм суурь зарчмууд байх ёстой шүү дээ. Одоо тэр нөгөө сая их олон дахин санал хураалаа л даа. Хэрэг хийсэн, хийж байгаа, хийж магадгүй, хийгдэж байгааг нь шалгаж байгаа хүмүүсийг бүгдийг нь юу яана гээд. Тэгээд би бол хуульчдыг тэгж л бид нарын одоо хүртэл үзэж ирсэн зарчим. Үүнийг ... /минут дуусав/

С.Бямбацогт: Одоо Болд гишүүн эхлээд нэг Болд гишүүн бол санал хураалгая гээд байгаа юм байна. Саналыг нь хураалгая. Гэхдээ та бол ажлын хэсэг дээр санал хураалгаад тэгээд унасан санал юм байна шүү дээ. Тэгээд одоо дахиад хураалгах гэж байгаа юм байна. Дахиад хураахад бол дэг байхгүй. Шинээр гаргасан бол түрүүн өгсөн байх ёстой шүү дээ. Энхболд гишүүнээс авхуулаад шаардаж байна шүү дээ. Хэзээ өгсөн юм бэ? Өгсөн байсан юм байна за.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.10-т эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ гэснийг эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн нам эвслээс гарсан хэдий ч 51 хувиас дээш тооны нам эвсэл нам уг эвсэлд үлдсэн тохиолдолд тухайн эвсэл хэвээр хадгалагдана гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болд. Болд гишүүн тайлбар хийе. Өөр үг хэлэх гишүүд байна уу? Энэ үгийг орхиж байгаа. Санал дууссан гэж бодоод уг нь яах вэ анхаарах юм бол байвал хэлье гэж бодсон юм.

Л.Болд: Зүгээр миний нэрээр явж байгаа. Энэ бол улс төрийн 23 нам Сонгуулийн хуультай холбогдож хэлэлцүүлэг хийгээд ажлын хэсэг гаргаад тэгээд ажлын хэсгийн ахлагчтай уулзсан. Ажлын хэсэгт төлөөлөл нь ирж асуудлаа тайлбарласан. Энэ санал бол цөөхөн саналаар унасан юм л даа. Гэхдээ энийг бол би зүгээр энэ улс төрийн олон намуудынхаа энэ улс төрийн хүсэл зоригийг дэмжээд энэ саналыг уг нь Байнгын хороон дээр дэмжигдчихвэл бас заавал тийм ээ энэ Сонгуулийн хуулийг нэг нам нэг эрх баригч нам дангаараа хийж байна,

хүчээр байна гэсэн нэг тийм асуудлаар явах шаардлагагүй байх гэж хараад байгаа юм.

Ялангуяа энэ намууд эвслээ байгуулаад тэр эвслээс нэг нам гарахаар л тар, та нар тарна шүү гэсэн ийм нэг сүх далайсан ийм маш тийм ардчилсан бус тогтолцоо байгаад хэрэггүй л байгаа юм л даа. Тэгээд олонх нь байвал тэр эвсэл нь байж л байг л дээ. Тэгээд энэ намуудын хүсэж байгаа ганц заалт энэ л юм байна лээ. Тэгээд энийг бид нар зүгээр Их Хуралд байгаа төлөөллийн хувьд зохион байгуулсан юм. Тэгээд бидний санал бодол бол бас янз бүрийн л ойлголттой байгаа. Гэхдээ энэ бол одоо нийт намуудын хүлээгдэж байгаа маш том хүлээлт байгаа учраас та бүхнийг дэмжээд өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 6 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо түрүүн бас микрофонд үг хэлье гэсэн Сонгуулийн хуультай холбоотой бас анхаарах саналууд юу байна вэ байна. Бид ажлын хэсэгт бас чиглэл өгөх манай гишүүдээс асуудлууд байвал ярья. Түрүүн Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Сонгуулийн хууль ер нь бол бидний байнга ярьдаг энэ хариуцлагатай их холбоотой зүйл дээ. Тэгээд яах вэ бид нар ингээд маазарч байгаад ерөнхийдөө Сонгуулийн хууль ингээд бас өнгөрчихдөг юм байна. Бэх яриад нөгөөхөө авчрах талаар тайлбар хийгээд. Одоо энэ нийгэмд бол яаж харагдаж байгаа вэ энэ арчаагаа алдсан хэдэн юм л гэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ бол бас Сонгуулийн ерөнхий хороо эд нар бас цаашдаа ялангуяа энэ нийгэмд хандаж байгаа энэ мэдээлэл дээрээ тайлбар өгөхдөө ч тэр бас жаахан хариуцлагатай бодолтой хандмаар байна.

Энд ерөөсөө маазраад байгаа хүн алга. Үндсэн хуулийн хэлэлцэх явцад нэг зүйлийг яах вэ байнга ярьж байгаад тэгээд сүүл рүүгээ мухардаад тэгээд маш олон гишүүдэд шоолуулаад өнгөрсөн зүйл бол энэ Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүстэй холбоотой асуудал байсан юм. Яах вэ эрхийг хязгаарлах тухай энэ ойлголтыг би ойлгож байгаа. Энэ бол үндсэн эрхтэй холбоотой асуудал. Хүний сонгох, сонгохтой холбоотой. Гэхдээ би хэн нэгэн хүнийг нэр цохож ч юм уу хэлээгүй шүү. Монгол Улсын Ерөнхийлөгч гэдэг хүнийг бол би л лав хүүхэд байхдаа манай аав, ээж энэ Монгол Улсын Ерөнхийлөгч. Энэ хүн шиг болохын тулд хичээх ёстой. Дэлхийн улс орнууд ийм л байдаг. Бахархдаг, хүндэлдэг. Тэр хүн шиг болоосой гэж сургууль дээр одоо хичээл заадаг. Зургийг нь албан байгууллагууд хүндлэн өлгөдөг.

Ийм хүмүүсийг бид нар Монгол Улсын төрийн тэргүүн гэж үздэг. Гэтэл харамсалтай нь Монгол Улсын төрийн тэргүүн байсан хүмүүс нийлж байгаад Монгол Улсаа бүхэлд нь самардаг ийм тогтолцоо руу Монгол Улс орлоо. Хууль хяналтын байгууллага энэ самарч түүгээрээ дамжуулж авлигал хээл хахуулын сүлжээ үүсгэнэ. Улс төрийн намуудыг худалдаж авна. Ил далд уулзалт хийнэ. Хэзээ ч биелэхгүй амлалтаар ард түмний одоо тархи эргүүлэх гэж оролдоно. Бага байхад нэг дэггүй жаалан зүггүй явдал гээд нэг кино байдаг байсан шүү дээ. Эсхүл нэг ералаш гээд хүүхэлдэйн кино дээр гардаг нэг ийм хэдэн үлгэрийн баатруудтай боллоо Монгол Улс.

Тэгээд яах вэ зөвхөн нэг удаа гэдэг энэ зүйлийг оруулах гээд яах вэ 6 жил гээд тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажилласан хүн цаашид улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно гэдэг үг оруулах гээд үнэхээр

дийлээгүй л дээ. Үндсэн хууль дээр. Болохгүй л гэсэн. Уг нь бол Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүстэй зориулж бид нар талбай тохижуулж өгдөг. Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүсийн намтрыг судалж дунд сургуулийн хичээл дээр үздэг. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүсийн нэрээр онгоцны буудлаа нэрлэдэг. Театрт Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн орж ирвэл бүгдээрээ босоод алга ташиж угтан авдаг. Ийм ёс зүйтэй, ийм хүмүүстэй л болмоор байх юм.

Одоо ингээд Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүс бүгдээрээ нэр дэвших нь. Одоо ингээд энэ байшин дотор орж ирээд ингээд нэг бүр нэг дээд тэнгэрээс нэг хэдэн хүмүүс орж ирээд ингээд нөгөө нэг хуучин холбоотой байсан хэдэн гишүүдээ дарамтлаад ингээд Төрийн ордны баруун, зүүн жигүүрт нэг баахан ийм нөхөдтэй болох нь. Энэ байдлыг бас би сая ажлын хэсгийн гишүүдтэй ч гэсэн бас уулзсан. Яах вэ энэ ингээд хаагдахгүй байх. Гэхдээ энэ ёс зүйгээр зохицуулагдахгүй байгаа асуудлыг дэлхийн бүх улс орнууд хууль, хэм, хэмжээгээр л зохицуулж байж бид нар нийгмийг шинэ түвшинд гаргах юм байна лээ. Тэрнээс биш 100 хувь бүх юм ёс зүйтэй болсны дараа бүх юм сайхан болно гэж бодвол энэ маш их урт хугацаа орох байх.

Тэгэхээр яах вэ энэ ингээд яах вэ протоколд ингээд үлдэг. Дараа дараагийн удаа энэ зүйлүүд дээр энэ ажиллаж байсан хүмүүс, ажиллаж байгаа хүн маань ч гэсэн их бодолтой хандаач ... /минут дуусав/

С.Бямбацогт: Батзандан гишүүн байхгүй. Пүрэвдорж гишүүн. Эхлээд Пүрэвдорж гишүүн. Болно, болно явж байж болно.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ сонгогчдын нэрсийн жагсаалтыг өгөх тухай асуудал санал маань одоо уналаа. Гэхдээ ер нь бол энэ сонгогчдын нэрсийн жагсаалтыг энэ сонгуулийг бас нэг хардлага багатай, бас нэг ил тод явуулахад хамгийн чухал нөлөөтэй зүйл гэж үзээд байгаа юм л даа. Тэгэхээр ер нь бол энэ дээр бол маш их хүндрэлтэй байх энэ тэр одоо газар бол хамгийн жижиг намууд, дээрээс нь бие даагч нар бол хүн хүчний багатай тэр хэсэг бол үнэхээр энэ сонгогчдын нэрийн жагсаалтыг авч чадахгүйгээс болоод маш тийм хүнд нөхцөлд сонгуульд орох тийм байдал руу орж байна.

Тийм учраас энэ сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг өгөх тухай асуудлыг маш дараагийн энэ Их Хурал дээр бас жаахан хүмүүст бас нэлээн ярья. Тэгээд энэ дээр бас гишүүд бас дэмжиж өгөх байх гэж найдаж байна. Тэгээд давхцахгүй өгөгдлийн асуудал байж байгаа. Давхцахгүй өгөгдөл. Тэгэхээр хурууны хээний асуудал байж байна. Тэгээд хамгийн гол нь бид нар энэ хумсан дээр тэмдэглэгээ хийх гэдэг асуудал дээр бид жишээ нь одоо юу байдаг юм бэ Бямбацогт гэж байлаа гэхэд Бямба гэдэг энэ хурууныхаа хээгээр өгөөд, тэрүүгээрээ одоо иргэний үнэмлэх авчихна. Цогт гэж энэ хуруугаараа өгөөд тэгээд Цогт дээрээ санал өгөөд явчих тийм боломжууд бас байж байгаа байхгүй юу. Энийг бол хийж болно шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү байдлаар энэ бол хардлага бол асар их гарч ирнэ. Яагаад гэвэл 2016 оны сонгуулийн сүүл рүүгээ гэнэтхэн баахан хүмүүс орж ирээд л ингээд энд тэнд санал өгөөд л саналын дүнг одоо өөрчлөөд байсан ийм зүйл ярьдаг. Тэгэхээр энэ дээр бол одоо ... /минут дуусав/

С.Бямбацогт: Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Сонгуулийн хуулийн төслийн асуудал яригдаж байна. Манай гишүүд энэ танхимаас бүгд гараад алга болсон байна. Сонгуулийн асуудалд хариуцлагатай хандаач гэж улс төрийн намууд болон энд байгаа гишүүд та бүхнээсээ хүсэх байна. Пүрэвдорж гишүүний хэлж байгаа бол туйлын үнэн. Хуруун дээр тэмдэглэгээ хийдэг энэ хуучны системийг бид ажиллуулах ёстой. Нэг хүн 2, 3 газар санал өгч байна гэдэг ийм гомдлууд сонгуулийн үеэр тасрахгүй гарч байгаа. Ийм учраас хурууны тэмдэглэгээг зайлшгүй хийх ёстой гэдэг энэ Пүрэвдорж гишүүний саналыг ШИНЭ нам дэмжиж байгаа та бүхэндээ дуулгахыг хүсэж байна.

2 зүйл дээр харамсал илэрхийлье. Дэлхийн улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ квотоор нэр дэвших эрхийг нь нээж өгдөг болоод удаж байна. Гэтэл өнөөдөр Баасанхүү, Батзандан болон ШИНЭ намын гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн квотоор Улсын Их Хуралд нэр дэвших, нэр дэвшигчдийн 3 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх нь зүйтэй гэдэг саналыг унагасанд харамсаж байна. Улсын Их Хурал дээр энэ асуудлыг дахин ярих ёстой гэдэг байр суурьтай байна.

Эцэст нь эрүүгийн гэмт хэрэгтнүүд авлига албан тушаалын гэмт хэрэгтнүүд охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хийсэн гэмт хэрэгтнүүд хүн амины гэмт хэрэгтнүүд Улсын Их Хуралд нэр дэвших эрхийг нь хориглох ёстой гэдэг байр суурийг эрх баригч нар эсэргүүцэж унагасанд харамсаж байгаагаа илэрхийлье. Чуулган дээр дахиж оруулна. Дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Тэгээд чуулганы хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Сонгуулийн хууль бол анх удаа батлагдаж байгаа хууль биш. 7 удаа Их Хурлын сонгууль болсон 7 удаа Сонгуулийн хууль Монгол Улсын Их Хурал баталсан. Энэ болгоноороо бас тодорхой алдаанууд нь засагдаад сайжраад ингээд ерөнхийдөө бол одоо хамгийн олон батлагдсан хууль гэх юм бол Сонгуулийн хууль. Тийм болохоор харьцангуй одоо юу гэдэг юм хий нь гарсан хууль. Мэдээж одоо тодорхой нөхцөл байдалтай уядуулж тодорхой зохицуулалт хийгдэж байгаа. Сонгуулийн хуулийг батлах гэж бас Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо хуулийн төслийг боловсруулж байх явцад сонгууль зохион байгуулахыг одоо оролцдог одоо хуулиар хүлээсэн үүрэг бүхий байгууллагууд дээр очиж тодорхой саналууд, тодорхой уулзалтууд, хэлэлцүүлэг хийсэн.

Мөн одоо бас албан ёсоор, албан бичгээр саналууд авсан. Өнөөдөр Сонгуулийн хуулийн ажлын хэсэгт бас одоо энэ байгууллагуудын төлөөлөл бас оролцоод явж байгаа. Эцэст нь сонгуулийг энэ байгууллагууд Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулна. Тийм болохоор та бүхэнтэйгээ хамтраад энэ Сонгуулийн хуулийг аль болох хийгүй, хийдэлгүй, ямар нэгэн зөрчил маргаангүй бас хийх тал дээр анхаарч ажиллаж байгаа. Тэгэхээр Сонгуулийн хууль дээр бас одоо юу гэдэг юм харьцангуй хийгүй, хийдэлгүй гараасай гэдэг дээр анхаарч байгаа. Энэ тал дээр одоо юу гэдэг юм ганц нэг гарч байгаа одоо саяын бэхний асуудал гэдэг юм уу иймэрхүү зүйл дээр одоо улс төр хийгээд байх бол шаардлага бол байхгүй. Нөхцөл байдал тодорхой ойлгомжтой байж байгаа.

Өнөөдөр 10 хуруугаараа тийм үү 10 иргэний үнэмлэх авсан тохиолдолд хэзээ ч гарахгүй ийм тохиолдол гарах юм бол 10 байтугай 1 иргэний үнэмлэх

дахиж авахад эрүүгийн хариуцлага хүлээх ийм хуулийн заалттай. Тийм болохоор одоо юу гэдэг юм сонгогчдыг төөрөгдүүлэх иймэрхүү худлаа үнэн мэдээллээр бас хямраах ийм бужигнуулах иймэрхүү сэдлүүдийг хийгээд байх шаардлагагүй гэдгийг бас энэ дашрамд бас хэлье. Ингээд өнөөдөр Сонгуулийн хуулийн анхны хэлэлцүүлэг хийгдэж дууслаа. Хэлэлцүүлэгт оролцсон бүх гишүүддээ баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга танилцуулна. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

